**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН**

**АУДИТЫН ГАЗАР**

# “Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн 2017 оны зарцуулалт, үр дүнд”-д хийсэн нийцлийн аудитын тайлан /ҮАГ-НАГ/2017/НА-01/











***ОНХС-гийн гүйцэтгэлд тавих хяналт, иргэдийн оролцоо хангалтгүй хэвээр байна.***

**СХС-ийн зээлийн зарцуулалтад хяналт тавиагүйгээс хугацаа хэтрэлттэй авлага өсчээ.**

2018 он

## АГУУЛГА

| | |
|---|---|
| Товчилсон үгс | 3 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй | 4-8 |
| **БҮЛЭГ 1. ОНХС-гийн хөрөнгийг хэсэгчлэн хувааж, үр дүн муутай жижиг арга хэмжээнд зарцуулж, гүйцэтгэлд тавих хяналт, иргэдийн оролцоо хангалтгүй байна.** | |
| 1.1. Төсвийн тухай хуулийн дагуу ОНХС- ийн хөрөнгийг төлөвлөж хуваарилсан байна. | 9-10 |
| 1.2. Зарим сумд ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн саналаар дэмжигдээгүй зориулалтын бус арга хэмжээнд зарцуулсан байна. | 10-21 |
| 1.3. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавиагүй, хэрэгжилтийг тайлагнаагүй байна. | 22-24 |
| 1.4 “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль тогтоомжтой нийцсэн байна. | 24 |
| **БҮЛЭГ 2 СХС-ийн зээлийн зарцуулалтад хяналт тавиагүйгээс, хугацаа хэтрэлттэй ихсэж, 1,235.0 сая төгрөгийн зээл хугацаандаа төвлөрүүлээгүй байна.** | |
| 2.1 Сумдууд СХС-ийн төсвийг зөвхөн дансны үлдэгдэл дүнгээр баталж, зарлагыг зээл олголт болон зардлаар нь салгаж батлахгүй байна. | 24-26 |
| 2.2 СХС-ийн зээлийн гэрээний заалтыг мөрдөөгүй, ажлын байр нэмэгдсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна. | 26-29 |
| 2.3. Сумдын СХС-ийн 2017 оны зарцуулалтад орон тооны бус зөвлөлийн хяналт хийгдээгүй, зээлийн хүү, авлагыг тайланд бүрэн тусгаагүй байна. | 29-30 |
| 2.4. Сум хөгжлийн сангийн журамд шүүх, шүүхийн шийдвэртэй холбогдолтой гарах зардал болон хариуцсан мэргэжилтэнд тавих шаардлагыг нэмж тусгах шаардлагатай байна. | 31-32 |
| **БҮЛЭГ 3. Өмнөх онд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.** | |
| 3.1 Өмнөх онд ОНХС-ийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хариуг 100 хувьтай ирүүлсэн ч зөрчил дахин гарсаар байна. | 32-33 |

Тайланг бэлтгэсэн:

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа

Аудитын менежер Х.Наранцацрал

Ахлах аудитор Д.Ихбаяр

Аудитор Д.Должинсүрэн

**Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70592225 дугаарын утсаар харилцана уу.**

Уг тайланг УАГ-ын вэб сайтаас үзнэ үү.

www.audit.mn

Хаяг:
Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 2 давхар

**2018 оны 11 дүгээр сар**

| | | |
|---|---|---|
| | 3.2. СХС-ийн өмнөх аудитын төлбөрийн актын хэрэгжилт 53.9 хувь, албан шаардлагын хэрэгжилт 77.9 хувьтай хэрэгжилт хангалтгүй, Өмнөх аудитын зөвлөмж хэрэгжээгүй байна. | 33-34 |
| | Дүгнэлт | 35 |
| | Зөвлөмж | 35-36 |
| | Дээд шатны байгууллагад хүргүүлэх санал | 36 |
| | Шалгагдагч байгууллагаас ирсэн санал, тайлбар | 37-38 |
| | Тайлан баталгаажуулах тушаал | 39 |
| | Тайлангийн хавсралтууд | 40-54 |


## ТОВЧИЛСОН ҮГС

| Товчилсон үг | Товчилсон үгийн тайлбар |
|---|---|
| УИХ | Улсын Их Хурал |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗҮ | Зөвлөх үйлчилгээ |
| БИНХ | Багийн иргэдийн нийтийн хурал |
| НТШ | Нээлттэй тендер шалгаруулалт |
| ОНО | Олон нийтийн оролцоотой |
| ХА | Харьцуулалтын арга |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ШГБ | Шууд гэрээ байгуулах |
| ТАХ | Төсөл, арга хэмжээ |
| ОНХНС | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| ХОХБТХ | Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс |
| ТБОНӨХБАҮХАТ | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт |
| ХАА | Худалдан авах ажиллагаа |
| ЗГ | Засгийн газар |
| МХГ | Мэргэжлийн хяналтын газар |
| ШХА | Шууд худалдан авалт |
| НАГ | Нийслэлийн аудитын газар |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэрлэл |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |
| ТЭЗҮ | Техник эдийн засгийн үндэслэл |
| МЭҮТ | Мал эмнэлэг үржлийн тасаг |

**АУДИТЫН НЭР: "ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН БОЛОН СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ ҮР ДҮН"**

**АУДИТЫН КОД: ДУАГ-НАГ/2018/НА-02**

## АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ:

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2018 оны "Аудитын сэдэв батлах тухай" 02 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/12 дугаар тушаалаар баталсан "Үндэсний аудитын газрын 2018 онд хийх аудитын төлөвлөгөө", Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

## НИЙЦЛИЙН АУДИТЫН ЗОРИЛТ

Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт гарган, илэрсэн зөрчлийг арилгуулах, эрсдэлийг бууруулах талаар санал, зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж аудитаар илэрсэн зөрчил дутагдлыг заасан хугацаанд нь арилгуулж, хууль, журмын хэрэгжилтийг хангуулахад аудитын зорилго чиглэгдлээ.

## ДЭД ЗОРИЛТ

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудыг дэвшүүлэн аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх;
- Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх.

## АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ

Аймгийн ИТХ, Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын СТСХ, ХОХБТХ, 15 сум, багийн Засаг дарга, ЖДҮ хариуцсан мэргэжилтэн, ОНХС, СХС-ийн баримт материалыг хамруулж, 2017 онд Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх санд улсын төсвөөс хуваарилж олгосон шилжүүлэг болон бусад эх үүсвэрээр бүрдүүлсэн хөрөнгийг хэрхэн зарцуулсан талаарх ажлын тайлан, зээлдэгчийн хувийн хэрэг бусад анхан шатны болон НББ-ийн журнал бусад холбогдох материал, эрх зүйн актуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэлээ.

## АУДИТЫН АРГА ЗҮЙ

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4000, 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Нийцлийн аудитын түр журмыг ашиглан, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс цуглуулан дүгнэлт, зөвлөмж боловсруулсан.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын дараах горимуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Аудитад хамрагдсан байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, лавлагаа, тодруулга авах, судалгаа хийх;
- Цуглуулсан мэдээ судалгаанд дүн шинжилгээ, харьцуулалт хийх;
- ОНХС-ийн үйл ажиллагаатай холбоотой иргэдээс санал авч, дүн шинжилгээ хийх;
- Сум хөгжүүлэх сангаас зээл авч үйл ажиллагаа эрхэлж байгаа төсөл хэрэгжүүлэгч нартай уулзаж, төслийн үр дүнтэй танилцах;
- ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, хөтөлбөртэй танилцан нөхцөл байдлын шинжилгээ хийх.

Аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийх, зорилт арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгах, судалгаа авах, мэдээллийн эх үүсвэртэй тулган шалгах арга зүйг ашиглалаа.

АДБОУС, Төрийн хяналт шалгалтын стандартад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

## АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:

Дараах хууль эрхийн актын холбогдох заалтыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн хяналт шалгалтын стандарт;
- Төрийн аудитын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244, 290, 264 дүгээр тушаал;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаал;
- Хууль зүй дотоод хэргийн сайд сангийн сайдын 2018 оны А/107/132 дугаар тушаал
- Бусад холбогдох эрх зүйн актууд;

## АУДИТЫН ХУГАЦАА, БАГИЙН БҮРЭЛДХҮҮН

Аудитын гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг 2018 оны 09 дүгээр сарын 20 –ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 30-ний өдрийг хүртэл хугацаанд тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, àõëàõ аудитор Д.Ихбаяр, аудитор Д.Должинсүрэн í àð õèéæã¿éöýòãýëýý.

## АУДИТЫН ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ, ТҮҮНД ТУСГАГДСАН МЭДЭЭЛЭЛ

Аудитын тайлангийн нэгдүгээр бүлэгт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хоёрдугаар бүлэгт Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх, гуравдугаар бүлэгт өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх талаар тусгаж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

## АУДИТЫН ДҮН

Аудитаар нийт 587.5 сая төгрөгийн зөрчил илрүүлэн 0.4 сая төгрөгийн хохирлыг барагдуулахаар хугацаатай төлбөрийн акт тогтоож, 587.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай 24 албан шаардлага хүргүүллээ.

Аудитаар илэрсэн зөрчлийг агуулгаар нь ангилбал:

***Орон нутгийн хөгжлийн сан:***

- Зориулалтын бус зардалд зарцуулсан 166.2 сая төгрөг буюу 14.8 хувь;
- Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж санхүүжүүлсэн 33.2 сая төгрөг буюу 33.2 хувь;
- Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн 18.0 сая төгрөг буюу 6.6 хувь;
- Бүртгэл, тайланд тусгаагүй 1.0 сая төгрөг буюу 0.4 хувь;
- ТЭЗҮ, зураг төсөв нь батлагдаагүй 167.6 сая төгрөг буюу 60.0 хувь;
- Орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй 54.4 сая төгрөг буюу 19.8 хувь;
- Захиалагчийн хяналт тавиагүй */Захиалагчийн албан зардлыг гйүцэтгэгч байгууллагад өгсөн./* 0.4 сая төгрөг буюу 0.1 хувийг тус тус эзэлж байна. *(Хавсралт №6* )

***Сум хөгжүүлэх сан:***

- *СХС-д бусад сангийн хөрөнгө байршуулсан 33.*4 сая төгрөг буюу 10.8 хувь;
- *Насжилт өндөртэй авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй 2.*7 сая төгрөг буюу 0.9 хувь;
- *Журмын 1.11 дэх хэсгийг зөрчин сонгон шалгаруулах тов ИТХ-аас зарлаагүй байхад төсөл сонгон шалгаруулсан 241.4 сая төгрөг буюу 77.1 хувь;*
- *Сонгон шалгаруулах орон тооны бус Зөвлөлийг журмын дагуу байгуулаагүй 1 сум /Хулд/;*
- Төсөл сонгон шалгаруулах комиссоор оруулаагүй Засаг даргын захирамжаар зээл олгосон 1.5 сая төгрөг буюу 0.5 хувь;
- Төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлээгүй 29.0 сая төгрөг буюу 9.2 хувь;
- Журмын 4.8 дахь хэсэг буюу хувийн хэргийн бүрдэл хангаагүй 3 сум; /Баянжаргалан, Дэлгэрхангай, Хулд /
- Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ аваагүй 1 сум / Хулд / байна.

- *Зээлийн хүү, алдангийг бүртгэл тайланд тусгаагүй 4.9 сая буюу 1.5 хувь (Хавсралт №16* )

Аудитын явцад аймгийн Ахмадын хороотой гэрээ байгуулан ОНХС-ийн зарцуулалтын талаар иргэдээс санал асуулга авах ажлыг гүйцэтгүүлж, судалгааны дүнг нэгтгэн, харьцуулалт хийж аудитын тайланд тусгасан.

Санал асуулгад тус аймгийн нийт хүн амын 5.5 хувь буюу 15 сумын хөдөлмөрийн насны 2570 иргэн хамрагдаж санал бодлоо илэрхийлсэн байна.

Санал асуулгад оролцогчдын 30.3 хувь нь 18-35 насны залуучууд, 25.1 хувь нь 36-45 насныхан, 18.4 хувь нь 45-51 насныхан, 17.1 хувь нь 52-60 насныхан, 9.1 хувь нь 61-ээс дээш насны иргэд байлаа.

Санал асуулгад оролцсон иргэдийн 20.3 хувь буюу 516 нь дээд, 33.5 хувь буюу 902 нь тусгай дунд ба бүрэн дунд, 1122 буюу 44.2 хувь нь бүрэн бус дунд, бага боловсролтой иргэд ээлж байна.

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

***Орон нутгийн хөгжлийн сан:***

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”-ыг мөрдөж байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”- ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Аймаг, сумын ОНХС-д 2017 онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас гүйцэтгэлээр 1,846.8 сая төгрөгийн санхүүжилтийг авч, орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас 729.6 сая, зарлагыг хэмнэх замаар болон ОНХС-гийн 2016 оны үлдэгдэл орлогоор 662.6 сая, хандив тусламжаар 25.5 сая, бусад эх үүсвэрээс 74.7 сая, нийт 3,339.2 сая төгрөгийн орлогын эх үүсвэр төвлөрсөн байна.

Аймаг болон сумдад ОНХС-гийн хөрөнгөөр 2017 онд хэрэгжүүлэх болон он дамжин хэрэгжүүлэх нийт 226 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас ОНХНС-гаас олгосон орлогын шилжүүлгийн хэмжээ буурсан тул төлөвлөсөн ажлын 89.4 хувь буюу 202 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээ дутуу буюу 80 хувьтай хэрэгжиж, 10.6 хувь буюу 24 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

***Сум хөгжүүлэх сан:***

Сумын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад сумандаа жижиг, дунд үйлдвэр байгуулах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, өргөтгөхөд нь дэмжлэг үзүүлэхэд зориулан эхний ээлжинд төсвийн хөрөнгийг эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулах

замаар сум хөгжлийн сан байгуулах эх үүсвэр бүрдүүлэхээр Монгол Улсын Засгийн газрын 1996 оны 258 тогтоолоор “Сум хөгжүүлэх сан”-г анх байгуулжээ.

Харин дээрх тогтоолыг 2001 онд ЗГ-ын 157 дугаар тогтоолоор, 2011 онд ЗГ-ын 157 дугаар тогтоолыг ЗГ-ын 134 дүгээр тогтоолоор, 2016 онд ЗГ-ын 153 дугаар тогтоолоор хүчингүй болгож, “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-ыг шинэчлэн баталсан байна.

Аймагт олгогдох Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн хэмжээг ЗГ-аас тогтоон хуваарилдаг бөгөөд 2011 оноос 2013 он хүртэлх хугацаанд Дундговь аймагт 3,000.0 сая төгрөг хуваарилагдаж байжээ. Үүнээс 2012 онд санхүүжилт олгогдоогүй байна.

Дундговь аймагт 2011 онд Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрт 1,000.0 сая төгрөг олгосныг дараах байдлаар хуваарилсан байна. Үүнд:

- Сайнцагаан суманд 265.0 сая төгрөг;
- Эрдэнэдалай суманд 75.0 сая төгрөг;
- Адаацаг суманд 60.0 сая төгрөг;
- Бусад суманд тус бүр 50.0 сая төгрөг.

2013 онд тухайн оны хуваарилагдсан санхүүжилт дээр 2012 оны олгогдоогүй санхүүжилтийг нэмж 2,000.0 сая төгрөг олгосныг дараах байдлаар хуваарилжээ. Үүнд:

- Сайнцагаан суманд 530.0 сая төгрөг;
- Эрдэнэдалай суманд 150.0 сая төгрөг,;
- Адаацаг суманд 120.0 сая төгрөг;
- Бусад суманд тус бүр 100.0 сая төгрөг.

Сум хөгжүүлэх санд 2014 оноос хойш ЗГ-аас санхүүжилт олгогдоогүй, зөвхөн үндсэн зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс санхүүжилт хийгдэж байна.

“Сум хөгжүүлэх сангийн зарцуулалт үр дүн”-д 2017 онд гүйцэтгэлийн аудит хийгдэж, Цагаандэлгэр, Говь-Угтаал, Гурвансайхан, Өлзийт, Эрдэнэдалай, Адаацаг, Сайнцагаан сумдыг хамруулсан байна. Тус аудитаар нийт 924.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс 516.3 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 94.6 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, 313.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй ажиллах зөвлөмж өгч, аудитын явцад 12.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийг нөхөн төлүүлж, зөрчлийг арилгуулан ажилласан байна.

Мөн 2018 оны санхүүгийн аудитаар нийт 297.1 сая төгрөгийн зөрчил ирүүлж, 28.6 сая төгрөгийн зөрчлийг арилган таслан зогсоохоор албан шаардлага, 472.9 сая төгрөгийн төлбөрийг барагдуулахаар хугацаатай төлбөрийн акт тогтоосон байна.

**_БҮЛЭГ 1._ ОНХС-гийн хөрөнгийг хэсэгчлэн хувааж, үр дүн муутай жижиг арга хэмжээнд зарцуулж, гүйцэтгэлд тавих хяналт, иргэдийн оролцоо хангалтгүй байна.**

## 1.1. Төсвийн тухай хуулийн дагуу ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөж, хуваарилсан байна.

ОНХНС-аас 2017 онд Дундговь аймгийн ОНХС-д нийт 1,846.8 сая төгрөгийн орлогын шилжүүлэг хуваарилсан бөгөөд 21.6 хувь буюу 399.1 сая төгрөгийг Тогтвортой амьжиргаа -3 төслийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээний урамшууллаас олгосон байна.

ОНХНС-аас хуваарилсан санхүүжилтийн дунд аймгийн Хот тохижуулах газрын зардалд */50 хувь буюу/* 117.6 сая төгрөг, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зардалд 236.0 сая төгрөгийг тусгаж өгчээ.

Дээрх 2 зардлыг 2016 оны Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтөөр ОНХНС-аас аймаг нийслэлийн ОНХС-д хуваарилагдаж байгаа хөрөнгөөр санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

ОНХНС-аас хуваарилсан орлогын шилжүүлгийг аймгийн Засаг дарга Төсвийн тухай хуулийн 59.2, 59.3-т заасан хувь, итгэлцүүрээр тооцож, 30.0 хувь буюу 328.2 сая төгрөгийг сумдад, 70 хувь буюу 765.9 сая төгрөгийг аймгийн төвд тус тус хуваарилан, хэрэгжүүлсэн байна. /Хавсралт №2/

Аймгийн ОНХС-ийн 2017 оны нийт орлогыг ИТХ-ын 2016 оны 11 дүгээр тогтоолоор 2,688.5 сая төгрөгөөр баталж, 2016 оны 15, 24 дүгээр тогтоолоор ОНХНС-аас олгох шилжүүлгийг 841.8 сая төгрөгөөр бууруулж, оны эхний үлдэгдэл орлогоос 662.6 сая төгрөг, орон нутгийн орлогын давсан орлогоос 729.7 сая төгрөг, хандив тусламж, бусад орлогоос 100.2 сая төгрөгийн орлого нэмэгдэж төвлөрүүлэхээр тооцон 648.0 сая төгрөгөөр буюу 19.4 хувиар нэмэгдүүлэн тодотгожээ. /Хавсралт №1/

Аймгийн хэмжээнд ОНХНС-гаас олгох шилжүүлгээс гадна 2016 оны төлөвлөгөөнөөс давсан орлого 733.2 сая төгрөг, аймаг, сумдын ОНХС-ийн үлдэгдлээс 662.6 сая төгрөг, хандив, тусламж болон бусад орлогоос 43.8 сая төгрөг */Дэрэн, Гурвансайхан, Хулд, Эрдэнэдалай сумд/* төвлөрүүлэхээр баталсан байна.




ОНХС-д 2017 онд ОНХНС-гаас 1,846.8 сая төгрөг, урьд оны үлдэгдэл 662.6 сая төгрөг, татварын орлогын төлөвлөгөөнөөс давсан орлогоос 729.6 сая төгрөг, хандив, тусламж болон бусад орлогоор 100.2 сая төгрөгийг тус тус төвлөрүүлж, гүйцэтгэлээр 3,339.2 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 566.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. /График: 1/ 2017 онд аймаг, сумдын ОНХС-д орон нутгийн татварын давсан орлого болон хандив, тусламжийн орлогоос нийт 463.4 сая төгрөгийг төвлөрүүлжээ. /Хавсралт № 2, 3/ Нийт орлогын эх үүсврийг график 1 –ээр харуулбал: Диаграммаас харахад аймаг, сумдын төсвийн төсөлд ОНХС-ийн орлогыг хуульд заасан нэр төрөл тус

бүрээр /ОНХНС-гаас олгох орлогын шилжүүлгээс бусад/ тооцоолж төлөвлөх, сангийн орлого нэмэгдүүлэхэд санаачилга гаргах шаардлагатай байна.

ОНХНС-аас санхүүжүүлэхээр 2017 онд батлагдсан 1,846.8 сая төгрөгийн санхүүжилтийг сумдад батлагдсан хуваарийн дагуу олгожээ.

Аудитын явцад аймгийн СТСХ-ийн тооцсон индексээр анх олгогдохоор баталсан төсөв болон сумдад хуваарилсан орлогын шилжүүлгийг дахин тооцоолоход зөрүү гараагүй болно.

Гүйцэтгэлээс үзэхэд бүх сумд батлагдсан төлөвлөгөөт санхүүжилтээ бүрэн авсан байна. /Хавсралт: №2, 3/

## 1.2. Зарим сумд ОНХС-ийн хөрөнгийг иргэдийн саналаар дэмжигдээгүй зориулалтын бус арга хэмжээнд зарцуулсан байна.

### 1.2.1 ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог бүрэн хангаж чадаагүй байна.

Аймаг, сумдад ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд болон он дамжин хэрэгжүүлэх нийт 226 төсөл, арга хэмжээ батлагдсанаас 89.4 хувь буюу 202 төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээ дутуу буюу 80 хувьтай хэрэгжиж, 10.6 хувь буюу 24 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна. /Хавсралт №7/

Аймаг, сумд тухайн жилийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд заасны дагуу ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж байгаа боловч сүүлийн жилүүдэд жижиг буюу урсгал шинжтэй арга хэмжээнд төлөвлөн зарцуулж байна.

*Тухайлбал:*

- *Энгийн уурхайн худаг засварлах /7 сум /*
- *Тоног төхөөрөмж худалдан авах / 15 сум, аймгийн төв/*
- *Өвс тэжээл авах / 4 сум /*
- *Албан хэрэгцээнд авто машин худалдан авах / 3 сум, аймгийн төв /*
- *Нийтийн эзэмшлийн урсгал зардал /4 сум /*
- *Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ /6 сум /*
- *Угтах, үдэх хаалга / 3 сум /*
- *Төсөл хөтөлбөр / 1 сум /*

2017 оны ОНХС-ийн хөрөнгийн ихэнх хувь буюу 37.3 хувийг тоног төхөөрөмж, 27.8 хувийг барилга байгууламж, 25.1 хувийг их засвар, 37.3 хувийг тоног төхөөрөмж, 6.8 хувийг баяр наадам, зураг төсөв, 3.8 хувийг малжуулах, өвс тэжээл бэлтгэхэд тус тус зарцуулжээ.

/График : 2/




Сумын дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлт байхгүйгээс ОНХС-ийн хөрөнгийг ирээдүйд үр өгөөж өгөх хөрөнгө оруулалтад биш ойрын хэрэгцээ шаардлагыг хангахад зарцуулсаар байна.

2015 оноос аймгийн хэмжээнд "Сумын ерөнхий төлөвлөгөө" бүх сумд хийлгэхээр төлөвлөсөн боловч тухайн онд ОНХС-ийн хөрөнгөөр Өндөршил, Гурвансайхан, Дэлгэрхангай сумд хийлгэж бусад сумд одоог хүртэл хийлгээгүй, дутуу гүйцэтгэлтэй, маргаантай байна.

*2017 онд Дэлгэрцогт – 29,0 сая, Говь-Угтаал-20.0 сая, Баянжаргалан 29,2 сая, Луус 15.3 сая, Сайхан-Овоо 28.7 сая төгрөг тус тус төлөвлөсөн боловч огт хийгдээгүй байна.*

Дээрх сумдын хувьд орон нутгийн дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлттэй болох ажлаа яаралтай шийдвэрлүүлж, түүнтэй уялдуулан томоохон, хөрөнгө оруулалтын шинж чанартай ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Мөн Баянжаргалан, Өлзийт сумд 2016-2020 онд хэрэгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлээ орон нутгийн сонгуулийн маргаантай асуудлаас болж батлуулаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгийг орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд тусгагдаагүй төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулжээ. Тухайлбал:

***Нийцлийн аудитаар илэрсэн асуудал:***

- *Дэрэн сумын "Цэцэрлэгийн гадна явган хүний зам хийх", "Хүн эмнэлэг, явуулын иргэний танхимын машины бэхэлгээ, тоноглол", "Соёлын төвийн гэрэлтүүлэг, техник хэрэгсэл" зэрэг төсөл, арга хэмжээ тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй; -**12.1 сая төгрөг***
- *Цагаандэлгэр сумын "Үлийн цагаан оготно устгах", "Халуун усны тоног төхөөрөмж, барилга засварлах, "Гэр хорооллын гэрэлтүүлэг", "Соёлын төвийн зөөврийн компьютер", "Сургуулийн сагсны шийд" зэрэг төсөл, арга хэмжээ тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй; - **54.4 сая төгрөг***

Цагаандэлгэр сум ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд халуун усны барилгыг 40.0 сая төгрөгөөр тохижуулан огт ашиглаагүй байж 2018 онд улсын төсвийн хөрөнгөөр 450.0 сая төгрөгийн өртөгтэй ахуйн үйлчилгээний барилга шинээр барьж эхэлсэн нь сумын удирдлагууд хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө бодлого, төлөвлөлтгүй ОНХС-ийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгааг харуулж байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар"-ын 3.5[1], 5.7[2] дахь хэсэг, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын

[1] ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тухай шатны ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлэхдээ тухай орон нутгийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй тайлбар үндэслэл иргэдийн хурлын санал тэдгээрийг тусгасан байдал гэсэн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана.

[2] Баг хорооны Засаг дарга иргэдийн Нийтийн хуралд иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, харьяа сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн/хэрэв байгаа бол / хөгжлийн бодлоготой уялдуулан төслийн санал болон хурлын явцад иргэдээс гарсан саналыг нэг бүрчлэн хэлэлцүүлнэ.

12.2.7[3] дахь заалттай нийцээгүй тул зөрчлийг арилгуулахаар 66.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Мөн 2016 онд 8 сум ***/Говь-Угтаал, Өндөршил, Гурвансайхан, Өлзийт, Луус, Дэлгэрхангай, Адаацаг, Сайнцагаан/*** ОНХС-ийн хөрөнгийг аймгийн чиг үүрэгт хамаарах хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд зарцуулсан зөрчил гаргасан бөгөөд 2017 онд дараах 2 суманд уг зөрчил дахин гарсан байна.

- *Өлзийт сум аймгийн чиг үүрэгт хамаарах "Сум хөх Бүрдийн тохижилтын ажлын дуусгалт"-ын ажилд хөрөнгө зарцуулсан нь тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй; -* ***38.0 сая төгрөг***
- *Эрдэнэдалай сум аймгийн чиг үүрэгт хамаарах "Мандалговь цэцэрлэгт хүрээлэнгийн дуусгалт"-ын ажилд хөрөнгө зарцуулсан нь тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй; -* ***50.0 сая төгрөг***

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.6.6[4], 60 дугаар зүйлийн 60.1[5], 14 дүгээр зүйлийн 14.1[6], 14.1.17 [7], 14.2[8], 14.2.4[9] дэх заалт, 63 дугаар зүйл[10]**,** 63.4[11] дэх хэсэг, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай" журмын 5 дугаар зүйлийн 5.10[12] дахь хэсэг болон Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2[13] дахь заалтыг зөрчсөн байна.

Мөн аймаг, сумд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэж, БИНХ-д хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг бэлтгэсэн боловч жагсаалтад Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 12.2.2[14]-т заасан зарим үзүүлэлтүүдийг тооцож тусгалгүй урьдчилсан жагсаалтыг нэр төдий бэлтгэж байна.

Төсвийн тухай хуульд баг, хорооны Засаг дарга ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулж, гарсан саналыг ИНХ хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгохоор заасан.

Сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө журамд заасан хугацаанд багийн иргэдээс санал авч нэгтгэн эрэмбэлсэн боловч "ОНХС-ийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээг тодорхойлох маягт"-аар баталгаажуулах ажил хангалтгүй хэвээр байна.

Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, иргэд, олон нийтийн оролцоог хангахдаа саналын хуудсаар нээлттэй санал асуулга авах, иргэдийн саналыг эрэмбэлж тухайн шатны ИТХ-д

[3] сум, дүүргийн Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргаж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ;

[4] тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр санхүүжүүлнэ

[5] Тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилго бүхий Орон нутгийн хөгжлийн сантай байна

[6] Дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна

[7] аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн.

[8] Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

[9] өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;,

[10] **Орон нутгийн төсөвт иргэд, олон нийтийн** оролцоог хангах

[11] Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь энэ хуулийн 63.3-т заасан саналыг хэлэлцэж, төсвийн төсөлд тусган, батална.

[12] Сум, дүүргийн ИТХ-нь сум дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нэгдсэн жагсаалтыг төсөл тус бүрээр хэлэлцэн төсвийн төсөлд тусган "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын сум/ дүүргийн ИТХ-ын хуралдааны тогтоол /загвар маягт/-ын 3 дугаар хавсралтын дагуу батална.

[13] Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ

[14] "Хөтөлбөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн өртөг"

өргөн мэдүүлсэн талаар баримт материал бүрдүүлсэн боловч иргэдийн оролцоо хангалтгүй байна. График 2




Аудитын явцад авсан “Танай баг, хорооны Засаг дарга 2017 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хамгийн түрүүнд хийх шаардлагатай ажлуудын саналыг иргэдээс авах ажлыг зохион байгуулсан уу?” гэсэн асуулгад судалгаанд оролцсон иргэдийн 29.7 хувь буюу 755 иргэн *“Тийм*”, 24.7 хувь буюу 626 иргэн *“Үгүй”*, **36.3** хувь буюу 923 иргэн ***“Сайн мэдэхгүй байна*”**, 9.3 хувь буюу 236 иргэн огт хариулаагүй бол “Та иргэдээс санал авах үйл ажиллагаанд оролцож саналаа өгсөн үү?” гэсэн асуулгад судалгаанд оролцсон иргэдийн 25.3 хувь буюу 642 иргэн *“Тийм*”, **48.2** хувь буюу 1,224 иргэн ***“Үгүй”*** гэсэн хариулт өгч, **26.5** хувь 675 иргэн **огт хариулаагүй** байна.

График 4




График 5




Харин “Засаг дарга ийнхүү авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийсэн үү?” гэсэн асуулгад судалгаанд оролцсон иргэдийн 25.0 хувь буюу 636 иргэн *“Тийм*”, 30.0 хувь буюу 762 иргэн *“Үгүй”,* **35** хувь буюу 888 иргэн ***“Сайн мэдэхгүй байна”*** *гэж* хариулсан бол “Та нээлттэй хэлэлцүүлэгт оролцсон уу?” гэсэн асуулгад судалгаанд оролцсон иргэдийн 29.0 хувь буюу 732 иргэн *“Тийм*”, **51.4** хувь буюу 1,306 иргэн ***“Үгүй”*** *гэсэн* харуилтыг тус тус өгсөн байна.

Дээрх санал асуулгаас харахад иргэдээс санал авах ажилд иргэдийг бүрэн хамруулах, авсан саналыг эрэмбэлж, хамгийн их санал авсан ажлуудыг иргэдэд танилцуулж, нээлттэй хэлэлцүүлэг хийх, өрх, бүлгийн ярилцлага хийх, цахим хэлбэрээр санал авах ажлыг үр дүнтэй зохион байгуулахгүй байна.

Иргэдээс ОНХС-ийн хөрөнгөөр хийх ажлын санал авах, хэлэлцүүлэх, эрэмбэлэхтэй холбоотой дараах саналууд ирсэн.Үүнд:

- *Төслийн талаар иргэдэд мэдээлэл сайн хүргэж,сурталчилж ил тод байдлыг хангах;*
- *БИНХ-ыг ирц муутай хийж байна. Цөөн тооны санал авч байгаа боловч эрэмбэлсэн болон хамгийн олон хүний санал авсан ажлыг иргэдэд танилцуулж баймаар байна;*
- *ОНХС-ийн санхүүжилтийн асуудалд малчдын идэвх оролцоог сайжруулах;*
- *Иргэдээс авах санал хүсэлтийг хуулийн хугацаанд нийтийг хамарч чанартай явуулах;*

- *Жил бүр энэ саналыг авдаг ч үр дүнгүй цаас бөглөхөөс хэтрэхгүй, судалгаанд өгсөн саналыг анхаарч үзэж ажил хэрэг болгодоггүй. Үр дүнгүй ийм судалгаа авах шаардлагагүй;*
- *БИНХ-д иргэдээ бүрэн оролцуулдаггүй. Хэдхэн хүн цуглуулж хурал хийж ОНХС-н хөрөнгөөр хийгдэх ажлыг хэлэлцүүлсэн болж зарамддаг;*
- *Сум багийн Засаг дарга нар иргэдтэй уулзаж санал хүсэлтийг сонсдоггүй. Хүлээн авсан санал хүсэлтийн хариуг огт эргэж мэдэгддэггүй.*

Дараах сумдын удирдлага иргэдийн саналаар дэмжигдээгүй, санал авч эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3[15], 60.3.1[16], 60.3.4[17],60.3.6[18] дахь заалт, 63 дугаар зүйлийн 63.1[19] дэх хэсэг, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.4[20] дэх хэсэг, 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” журмын 12 дугаар зүйлийн 12.2.5[21] дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

***Нийцлийн аудитаар илэрсэн асуудал:***

- *Гурвансайхан сумын “Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх”, “SSS-д байрлаж байгаа сумын төвийн номын сан болон албан өрөөнд халаалтын систем тавих”, “Гадна хяналтын камерын тоног төхөөрөмж”, “Иргэний танхимд тоног төхөөрөмж нийлүүлэх” зэрэг ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй – **33.2 сая төгрөг***

***СТА-аар илэрсэн асуудлууд :***

- *Дэрэн сумын “Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн авто машины урсгал засвар хийх” ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, зориулалт бус -**4.0 сая төгрөг***
- *Цагаандэлгэр сумын “Цагдаагийн согтууруулах ундаа хэрэглэсэн үед хэмжих багаж хэрэгсэл худалдан авах”, “Цэцэрлэгийн зураг төсөв хийлгэх” ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, зориулалт бус - **2.7 сая төгрөг***
- *Баянжаргалан сумын “Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн авто машинуудад урсгал засвар хийх” ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, зориулалт бус - **5.1 сая төгрөг***
- *Өлзийт сумын “Цагдаагийн торгуулийн тоног төхөөрөмж” худалдан авах ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, зориулалт бус – **2.5 сая төгрөг***
- *Хулд сумын “Цагдаагийн торгуулийн тоног төхөөрөмж”, Цагдаагийн авто машин” худалдан авах ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, зориулалт бус – **13.7 сая төгрөг***
- *Эрдэнэдалай сумын “Төсөл хөтөлбөр”, “ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгүүдэд урсгал засвар хийх” ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, зориулалт бус – **7.7 сая төгрөг***
- *Луус сумын “Цагдаагийн торгуулийн тоног төхөөрөмж” худалдан авах ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, зориулалт бус – **2.5 сая төгрөг***

---

[15] Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно

[16] Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга хэмжээ

[17] Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

[18] Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

[19] Баг, хорооны Засаг дарга Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулна

[20] Аймаг нийслэл сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх болон урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй

[21] Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхийн санал авсан дараалаар нь эрэмбэлж багцална/ ум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь баг, хорооны иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлсэн саналыг нэгтгэн орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан, дүн шинжилгээ хийн, олонхийн санал авсан дараалаар нь эрэмбэлж багцална

- *Сайнцагаан сумын “Цагдаагийн бэлэн бус торгуулийн тоног төхөөрөмж худалдан авах”, “Олон нийтийн цагдаа нарыг унаажуулах”, “Сумын цагдаагийн кабоны барилга, аймгийн цагдаагийн постны барилгыг дулааны шугамд холбох засварын ажил” худалдан авах ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, зориулалт бус –**12.2 сая төгрөг***
- *Аймгийн ОНХС-ийн “Адаацаг сумын ЗДТГ-ын авто машины парк шинэчлэл” ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй, зориулалт бус –**50.0 сая төгрөг***

***Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтаар:***

- *Адаацаг сумын “Ахмадын өргөөний засвар, Морьтой саадыг тохижуулах, Хүүхдийн цэцэрлэгт ор нийлүүлэх, Соёлын төвд урлагийн гутал” худалдан авах ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй,*
- *Баянжаргалан сумын “Цэцэрлэгт хүрээлэнгийн мод услах”, “Гэрэлт цамхгийн цахилгааны төлбөр төлөх”ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй,*
- *Баянжаргалан сумын “Цэцэрлэгт хүрээлэнгийн мод услах”, “Гэрэлт цамхгийн цахилгааны төлбөр төлөх” ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй,*
- *Аймгийн ОНХС-ийн “Аймгийн төвийн ундны усны гүний худгийн хяналтын камер”, “Зөөврийн тайз”, “Цахим аймаг хөтөлбөрийн тоног төхөөрөмж”, “Адаацаг сумын ЗДТГ-ын автомашины парк шинэчлэл”, “МХГ-ын ажилчдын орон сууцны дэд бүтэц” ажил нь иргэдийн саналаар дэмжигдээгүй.*

ОНХС-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитаар илэрсэн дээрх зөрчлийг арилгуулахаар 95.3 сая төгрөгийн албан шаардлага, нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 33.2 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх томоохон барилга байгууламжийн зураг төсвийг эрх бүхий байгууллагаар хийлгэж, тоног төхөөрөмж, бусад зүйлийн төсвийг захиалагч байгууллага өөрөө хийсэн байна.

2017 онд аймгийн төв болон 5 суманд сангийн хөрөнгөөр хийгдэх 10 ажлын зураг төсөвт 56.4 сая төгрөг зарцуулжээ.

2017 онд Цагаандэлгэр сум ОНХС-аас улсын төсвийн хөрөнгөөр хийгдэх "Цэцэрлэгийн барилга"-ын засварын ажлын зураг төсвийн зардалд 1.0 сая төгрөг зарцуулсан боловч санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.4[22], 14.4.2[23], 20 дугаар зүйл 20.2.5[24], 20.2.6[25] дахь заалтуудтай нийцээгүй тул зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй төсөл, арга хэмжээг баталж, хэрэгжүүлсэн нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал:

***Нийцлийн аудитаар илэрсэн асуудал:***

- *Гурвансайхан сумын “Цэвэрлэх байгууламж хүйтнээс хамгаалах нэмэлт тоноглох ажил”, “Сумын төвийн усны нөөцийн сангийн их засвар”, “Зөөврийн угсардаг тайз, дэлгэц, гэрэлтүүлэг нийлүүлэх” , “Гадна хяналтын камерын тоног төхөөрөмж”, “Иргэний танхимд тоног төхөөрөмж нийлүүлэх” , “SSS-д байрлаж байгаа сумын төвийн номын сан болон албан өрөөнд халаалтын систем тавих” зэрэг ажил нь зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй –*

[22] Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:

[23] бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

[24] дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

[25] эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

***121.7 сая төгрөг***

- *Гурвансайхан сумын ““ЕБС-ийн авто клав, үдийн цайны аяга тавагны ариутгал, аяга таваг худалдан авах”, “Цахим бүртгэл” “Ёслол хүндэтгэлийн өргөөний тохижилт, тоног төхөөрөмж” зэрэг ажил нь зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй -* ***33.8 сая төгрөг***
- *Цагаандэлгэр сумын “Үлийн цагаан оготно устгах ажил”, “Халуун усны тоног төхөөрөмж, барилга засварлах, ” “Гэр хорооллын гэрэлтүүлэг”, “Соёлын төвийн зөөврийн компьютер”, “Сургуулийн сагсны шийд” зэрэг ажил нь зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй -* ***54.5 сая төгрөг***

***Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтаар:***

- *Дэлгэрхангай сумын “Хүндэтгэлийн хаалга барих”, “Нэг цэгийн үйлчилгээний төвийн дотор гадна засвар” зэрэг ажил нь зураг төсөвгүй, ТЭЗҮ-гүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй -* ***40.0 сая төгрөг***

Дээрх зөрчил нь төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2[26], 29 дүгээр зүйлийн 29.4[27], Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 4.7[28], 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай” журмын 6 дугаар зүйлийн 6.3.3[29] заалтуудыг зөрчсөн тул тус аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар 155.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн. *(Цагаандэлгэр сумын 54,5 сая төгрөгийн зөрчлийг өмнөх хэсэгт зөрчлийн дүнд оруулсан.)*

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төсвийг боловсруулахдаа зах зээлийн судалгаа хийж тоног төхөөрөмжийн үзүүлэлт, хүчин чадал, цаашид гарах урсгал зардлын тооцоог хийлгүйгээр хэт өндөр үнээр төлөвлөж, худалдан авсан байна.

*Тухайлбал:*

*Луус сумын ЭМТ өндөр үнэтэй биохимийн шинжилгээний аппарат авсан болович гол шаардлагатай шинжилгээний бодис, урвалж өндөр үнэтэй авах боломжгүй ажиллахгүй байна.-* ***17. сая төгрөг***

*Эрдэнэдалай сумын ЭМТ биохимийн шинжилгээний аппарат авсан болович зааварчилгаа аваагүйгээс ажиллуулах боловсон хүчин байхгүй, гол шаардлагатай шинжилгээний бодис, урвалж өндөр үнэтэй, авах боломжгүйгээс огт ашиглаагүй байна.-* ***5.6 сая төгрөг***

*Харин Дэлгэрхангай, Цагаандэлгэр сумдын ЭМТ-үүдийн худалдан авсан биохимийн шинжилгээний аппаратын шинжилгээ хийх бодис урвалж нь боломжийн үнэтэй, олцоц ихтэй байдаг тул ашиглаж тухай сумандүр өгөөжөө өгч байна.- Дэлгэрхангай -**15.0 сая**, Цагаандэлгэр –* ***8.0 сая төгрөг***

Дээрх байдлаас дүгнэхэд хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө бусдыг дуурайж асуудалд хөнгөн хандах бус хөрөнгийн үнэ өртөг, үзүүлэлт, ашиглалтын явцад гаргах зардал, иргэдэд үзүүлэх үр нөлөө зэргийг нарийвчлан судлах шаардлагатай байна.

### 1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөс 104.1 сая төгрөгийг зориулалтын бус зүйлд зарцуулж, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

[26] өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох;

[27] Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

[28] Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй.

[29] хөрөнгө, оруулалтын төсөл хөтөлбөр арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөв нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх

ОНХС-ийн хөрөнгөөр 2017 онд 215 худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөж, 91.6 хувь буюу 197 худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ.

Нийт төсөл, арга хэмжээний 2.8 хувь буюу 6 ажлыг нээлттэй тендер, 19.5 хувь буюу 42 ажлыг харьцуулалтын арга, 50.7 хувь буюу 109 ажлыг шууд худалдан авалт, 27.0 хувь буюу 50 ажлыг олон нийтийн оролцоотой болон зөвлөх үйлчилгээний аргыг сонгон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

График : №5




Графикаас харахад ШХА болон ОНО-ны аргаар худалдан авах төсөл, арга хэмжээ 23.3 – 50.7 хувийг эзэлж байгаа нь ОНХС-ийн хөрөнгө сүүлийн жилүүдэд буурсан, сумдын удирдлага худалдан авах ажиллагааг зохион байгуулахаас төвөгшөөж, хөрөнгө оруулалтыг хэсэгчлэн хуваан, өртгийг бууруулан, ашиг сонирхол үүсгэж шууд худалдан авалт хийсэнтэй холбоотой байна.

Гүйцэтгэлээр НТШ-5, ХА-21, ШХА/ШГБ-120, ЗҮ-1, ОНО-50 нийт 197 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. */Хавсралт №4,5/*

График 6




Графикаас харахад ихэнх ажлууд нь ХА болон ШХА-аар хийх ажлууд төлөвлөгдөж хийгдсэн байна.

2017 онд НТШ, ХА, ЗҮ -ээр хийх ажлын гүйцэтгэл буурч, ШХА, ШГБ арга өссөн нь төлөвлөсөн ажлаас 18 ажил хийгдээгүй, ХА-аар зарласан тендер амжилтгүй болж шууд гэрээ байгуулсан, зөвлөх сонгох бага үнийн аргаар хийх ажлыг шууд худалдан авалтын аргаар хийсэнтэй холбоотой байна.

Цагаандэлгэр, Өндөршил, Хулд, Дэлгэрхангай сумд ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.22[30], 8 дугаар зүйлийн, 8.1[31], 8.1.2[32],8.1.3[33], дахь заалтууд, 8.4[34] дэх хэсэг, Төсвийн тухай

[30] бага үнийн арга" гэж захиалагчийн тогтоосон техникийн санал авбал зохих доод оноотой тэнцүү буюу түүнээс дээш оноо авсан зөвлөхүүдээс хамгийн бага үнэ санал болгосон зөвлөхийг шалгаруулахыг

[31] .Засгийн газар нь барааны, ажлын, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр дараах босго үнийг тогтооно.

[32] Шууд худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

[33] Зөвлөх сонгох бага үнийн аргыг хэрэглэж болох зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;

[34] Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.

хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4[35] дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.4[36] дэх хэсгийг зөрчин зөвлөх сонгох бага үнийн аргаар хийх */Зураг төсөв хийлгэх /* ажлыг шууд худалдан авалтын аргаар хийсэн зөрчлийг арилгуулахаар 18.0 сая төгрөгийн албан шаардлага өгсөн.

Цагаандэлгэр сумын Засаг дарга 2017 онд ОНХС-ийн хөрөнгөөр “Халуун усны барилгын засвар, тоног төхөөрөмж нийлүүлэх” 40.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг 2 хувааж тус бүрд нь 20.0 сая төгрөгийн өртөгтэйгөөр тендер зарлаж харьцуулалтын арга хэрэглэсэн боловч 2 ажлын тендерийн урилгыг ижил 3 компанид өгч 1 компани буюу П.Отгондэлгэр захиралтай “Тааны амт” ХХК- ийг шалгаруулж 2 ажлаа гүйцэтгүүлсэн нь худалдан авах ажиллагаа хууль бус , ашиг сонирхлын зөрчил үүсгэсэн байх магадлалтай байна. Тус асуудал нь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны 2018 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрч уг асуудлыг шалгуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байна.

Дээрх байдлаас дүгнэхэд сумдын Засаг дарга, Засаг даргын орлогч дарга худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа сангийн хөрөнгийг үр дүнтэй ажилд зарцуулах гэхээсээ илүү хувьдаа ашиг хонжоо хайх зорилгоор ашиг сонирхол үүсгэж, хууль, журмыг мөрдөхгүй, төсвийн хөрөнгийг хяналтгүй зарцуулсан байна.

Цаашид ОНХС-ийн хөрөнгийн худалдан авах ажиллагааг үр дүнтэй, хуулийн дагуу зохион байгуулаагүй, хувьдаа ашиг хонжоо хайх зорилгоор ашиг сонирхол үүсгэсэн аймаг, сумдын Засаг дарга нарт хатуу хариуцлага тооцох цаг болсон байна.

Аймгийн хэмжээнд 2017 онд нийт 226 арга хэмжээнд 2,982.8 сая төгрөгийг төлөвлөж, 202 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 2,419.2 сая төгрөгийг зарцуулсан. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт:№1

**Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хийгдсэн ажлын төлөвлөгөө, гүйцэтгэл**

| № | Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр | Батлагдсан төсөл хөтөлбөр | | Хэрэгжсэн төсөл хөтөлбөр | | Хэрэгжилтийн хувь | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тоо | өртөг | тоо | өртөг | тоо | өртөг |
| 1 | Дэлгэрцогт | 8 | 52.3 | 7 | 22.2 | 87.5 | 42.4 |
| 2 | Дэрэн | 9 | 112.9 | 8 | 77.6 | 88.9 | 68.7 |
| 3 | Говь-Угтаал | 8 | 62.9 | 6 | 36.1 | 75.0 | 57.4 |
| 4 | Цагаандэлгэр | 17 | 115.5 | 14 | 80.8 | 82.4 | 70.0 |
| 5 | Баянжаргалан | 11 | 158 | 7 | 50.8 | 63.6 | 32.2 |
| 6 | Өндөршил | 8 | 128.4 | 8 | 117.2 | 100.0 | 91.3 |
| 7 | Гурвансайхан | 10 | 144.3 | 10 | 137.5 | 100.0 | 95.3 |
| 8 | Өлзийт | 11 | 120.7 | 8 | 83.7 | 72.7 | 69.3 |

35 Хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох

36 Төсвийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Хулд | 15 | 112.2 | 15 | 112.2 | 100.0 | 100.0 |
| 10 | Луус | 7 | 82.5 | 5 | 56.9 | 71.4 | 69.0 |
| 11 | Дэлгэрхангай | 7 | 83.5 | 7 | 79.3 | 100.0 | 95.0 |
| 12 | Сайхан-Овоо | 6 | 76 | 5 | 47.3 | 83.3 | 62.2 |
| 13 | Эрдэнэдалай | 59 | 176.3 | 59 | 176.2 | 100.0 | 99.9 |
| 14 | Сайнцагаан | 18 | 129.4 | 15 | 102.2 | 83.3 | 79.0 |
| 15 | Адаацаг | 11 | 108.1 | 9 | 79 | 81.8 | 73.1 |
| 16 | Аймгийн ОНХС | 21 | 1,319.80 | 19 | 1,160.20 | 90.5 | 87.9 |
| | **Аймгийн нийт дүн** | **226** | **2,982.8** | **202** | **2,419.2** | **89.4** | **81.1** |

Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний төлөвлөгөө гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулахад батлагдсан төсөл, хөтөлбөрийн тоо 3 –аар, санхүүжилт 2,546.1 сая төгрөгөөр тус тус буурсан, хэрэгжсэн төсөл, хөтөлбөрийн тоо 17–гоор нэмэгдэж, санхүүжилт 2,412.7 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. График: 7




Сангийн хөрөнгийн хэмжээ буурсан шалтгаан нь ОНХНС-гаас олгох шилжүүлгийн хэмжээ 36.3 хувиар буурсан, төсвийн ерөнхийлөн захирагч нар сангийн орлогын эх үүсвэрийг төлөвлөхдөө тооцоо судалгаа хийж төлөвлөөгүй, орлого нэмэгдүүлэх чиглэлээр санаачилгагүй ажилласантай холбоотой байна.

Харин 2017 онд хийсэн ажлын тоо өмнөх оноос 9 хувь буюу 17 ажлаар өссөн байна.

Цаашид сангийн хөрөнгийг бодитой томоохон хөрөнгө оруулалтын ажилд зарцуулах бодлого, чиглэл барьж иргэдийн санал санаачилгыг өрнүүлж ажиллах цаг болсон байна.

ОНХС-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитаар Дэлгэрцогт, Адаацаг, Өндөршил, Дэлгэрхангай, Говь-Угтаал, Гурвансайхан, Сайхан-Овоо зэрэг сумдаас бусад сумдад ОНХС-ийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан 104.1 сая төгрөгийн зөрчил илэрснийг тайлангийн **1.2.1** дэх хэсэгт дэлгэрэнгүй оруулсан.

Аймаг, суманд шинээр баригдаж байгаа их засвар үйлчилгээ, болон бусад чиглэлээр хийгдэж байгаа томоохон ажилд аймгийн ГХБХБ-ын алба явцын хяналт хийж байна.

Харин ихэнх сумдын удирдлагууд гэрээний хугацааг баримтлаагүй, ажлын даалгаврыг өөрчилсөн, захиалагчийн хяналт хийсэн гэж байгаа боловч, захиалагчийн хяналт тавьсан тайлан, акт үйлдээгүй байлаа.

Захиалагчийн албаны зардлыг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн зөрчил дараах газруудад илэрлээ. Тухайлбал:

***Нийцлийн аудитаар илэрсэн асуудал:***

- *Луус сумын 2017 оны ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн "Нэг цэгийн үйлчилгээ иргэний танхимын халаалтын засвар"-ын ажлын гүйцэтгэгч "ЭДМООР" ХХК-д засварын ажлын төсөвт тусгагдсан захиалагчийн албаны хяналтын зардлыг олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан -**0.4 сая төгрөг;***

***Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтаар:***

- *Аймгийн болон Цагаандэлгэр сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын захиалагчийн албаны зардал, инженер хайгуул, зураг төсвийн зардал, зураг төсөл зохиогчийн хяналтын зардал, магадалшгүй ажлын зардлыг гүйцэтгэгч байгууллагад олгосон 4.5 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна.*

Захиалагчийн албаны зардлыг гүйцэтгэгч байгууллагад шилжүүлсэн зөрчил нь Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3[37] дахь заалт, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-ын 4.18[38] дахь хэсэгтэй нийцэхгүй байгаа тул нийцлийн аудитаар 0.4 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

Цаашид ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд захиалагч байгууллагаас тавих хяналтыг тогтмол хийж, түүнийгээ баримтжуулах хэрэгтэй байна.

ОНХС-ийн дансанд 963.1 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг /*11 сум малжуулах төслийн мал*/ бүртгэж тайлагнажээ. Сангийн хөрөнгөөр хийгдсэн үндсэн хөрөнгийг Засаг даргын захирамжаар томилогдсон эрх бүхий комиссын актаар хүлээн авч, ИТХ-ын шийдвэрээр ЗДТГ болон хөрөнгийг ашиглагч байгууллагын бүртгэл тайланд тусгасан.

2017 оны ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон нийт 1,447.2 сая төгрөгийн хөрөнгийг аймаг, сумын ЗДТГ болон бусад төсөвт байгууллагад Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4[39],14.4.2[40], аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан "Орон нутгийн хуулийн этгээдийн олж авсан эд хөрөнгийг бүртгэх"-журмын 3 дугаар зүйлийн 3.2[41] дахь хэсгийн дагуу бүртгэл тайланд тусгажээ. /Хүснэгт: №2/

Харин Дэлгэрхангай, Цагаандэлгэр суманд гарсан дараах 3 зөрчлийг аудитын явцад зөвлөмж өгч зөрчлийг арилгууллаа. Тодруулбал:

- *Дэлгэрхангай сум засварын ажлыг барилгад сайжруулалтаар бүртгээгүй, шууд зардалд бичсэн;*
- *Цагаандэлгэр сум "Оготно устгал"-ын ажлын хүрээнд сангийн хөрөнгөөр бий болгосон хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй;*
- *Цагаандэлгэр сум халуун усны ямар тоног төхөөрөмж хүлээн авсан нь тодорхой бус байхад бүртгэл тайланд бөөн дүнгээр тусгасан.*

[37] барилгын үнэ бүрдэл, төсвийн норм, нормативын баримт бичиг, дүрэм, заавар, аргачлалыг удирдлага болгосон байх;

[38] Захиалагч барилгын ажлын зардал, ТЭЗҮ, зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт, материалыг үндэслэн шилжүүлнэ

[39] Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ

[40] бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;

[41] Улсын хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн зохих баримт материалыг үндэслэн тухайн төсөл хэрэгжсэн байгууллага нь тайлан балансдаа шууд бүртгэн авна.

Аймгийн хэмжээнд ОНХС-гийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд нийт 2,025.3 сая төгрөгийн өр төлбөр, 711.9 сая төгрөгийн авлагыг тус тус тайлагнасан.

2017 оны санхүүгийн аудитаар зарим сумд тайлант онд үүссэн авлага, өр төлбөрөө бүртгээгүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4[42],14.4.2[43], аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан “Орон нутгийн хуулийн этгээдийн олж авсан эд хөрөнгийг бүртгэх”-журмын 3 дугаар зүйлийн 3.2[44] дахь заалтыг зөрчсөн тул зөрчлийг арилгуулахаар 9 суманд 272.4 сая төгрөгийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. /Хүснэгт: №2/

Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд бүртгэсэн хөрөнгө, өглөг, авлага болон баталгаажуулаагүй өглөг, авлагын судалгаа /2017 он/ Сая.төг

| № | Сумын нэр | Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд бүртгэсэн хөрөнгийн судалгаа / мян.төг / | | ОНХС-ийн СТА-аар тайлагнасан | | Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | Дүн | Мал амьтад | Өглөг | авлага | Өглөг | авлага |
| | | | Дүн | Дүн | Дүн | Дүн | Дүн |
| 1 | Дэлгэрцогт | 45.0 | 45.0 | | | | |
| 2 | Дэрэн | 155.9 | 155.9 | | 8.0 | | 8.0 |
| 3 | Говь-Угтаал | 6.6 | 6.6 | 0.9 | 29.0 | 0.9 | 29.0 |
| 4 | Цагаандэлгэр | 40.0 | 40.0 | | 3.0 | | 3.0 |
| 5 | Баянжаргалан | | | 0.2 | 34.0 | 0.2 | 4.5 |
| 6 | Өндөршил | | | 5.9 | 62.0 | | 62.0 |
| 7 | Гурвансайхан | | | 1887.5 | 47.7 | | 47.7 |
| 8 | Өлзийт | 163.3 | 163.3 | 3.0 | 1.2 | | |
| 9 | Хулд | 79.9 | 79.9 | | 13.0 | | |
| 10 | Луус | 30.0 | 30.0 | | | | |
| 11 | Дэлгэрхангай | 117.8 | 117.8 | | 30.0 | | 30.0 |
| 12 | Сайхан-Овоо | 97.5 | 97.5 | | 23.9 | - | 23.9 |
| 13 | Эрдэнэдалай | | | | 93.0 | | 93.0 |
| 14 | Адаацаг | 100.0 | 100.0 | | - | - | - |
| 15 | Сайнцагаан | 127.2 | 127.2 | - | | - | |
| 16 | Аймгийн төв | | | 130.8 | 367.1 | | |
| | **Дүн** | **963.1** | **963.1** | **2,053.3** | **711.9** | **1.1** | **301.1** |

[42] Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ
[43] бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага;
[44] Улсын хөрөнгө оруулалт болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг ашиглалтад хүлээн авсан Улсын комисс /Ажлын хэсэг/-ын акт, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн зохих баримт материалыг үндэслэн тухайн төсөл хэрэгжсэн байгууллага нь тайлан балансдаа шууд бүртгэн авна.

## 1.3. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавиагүй, хэрэгжилтийг тайлагнаагүй байна.

### 1.3.1 ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтөд хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавиагүй байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын *”ОНХС-гийн хяналт шинжилгээ ба үнэлгээ”* 9.1[45], 9.4[46] дэх хэсгийг Луус, Хулд, Эрдэнэдалай, Дэрэн, Баянжаргалан сумдаас бусад сумд болон аймгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хэрэгжүүлээгүй байна.

Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээ бодитой хэрэгжиж байгаад иргэд хяналт тавьж байгаа эсэх талаар иргэдээс авсан санал асуулгаар судалгаанд оролцсон иргэдийн 25.0 хувь нь хяналт тавьдаг, 66.9 хяналт тавьдаггүй гэсэн хариулт өгч, 8.1 хувь нь огт хариулаагүй байна.

Энэ нь судалгаанд хамрагдсан иргэдийн ихэнх хувь нь хууль эрх зүйн мэдлэг дутмаг, ОНХС-ийн талаарх мэдээлэл муу, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллах нөхцөл бүрдээгүй байгааг харуулж байна.

Иймд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийг тэгш, хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэх, хууль тогтоомжийг сурталчлах талаар анхаарч ажиллах шаардлагатай байна.

Санхүүгийн хяналт, аудитын алба 2018 онд Адаацаг, Баянжаргалан, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Өлзийт, Сайхан-Овоо, Сайнцагаан зэрэг 7 сум болон аймгийн ОНХС-гийн 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд батлагдсан удирдамжийн дагуу санхүүгийн төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, “Хууль эрхийн хэрэгжилт хангалтгүй, хяналтын систем муу байна” гэсэн дүгнэлтийг өгчээ.

Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо ОНХС-аас хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийж ажиллаагүй нь ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй зарцуулагдах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймд ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын холбогдох заалтыг цаашид хэрэгжүүлж ажиллах шаардлагатай.

### 1.3.2. Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ ОНХС-ийн явцын хэрэгжилтийг тайлагнаагүй, үр дүнд огт дүн шинжилгээ хийгээгүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнгийн тайланг Сангийн яаманд хүргүүлсэн эсэхийг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн мэргэжилтнээс тодруулахад “Улсын төсвийн санхүүжилтээр хийгдсэн хөрөнгө оруулалтын явцын мэдээллийг хүргүүлдэг, ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг Сангийн яаманд хүргүүлдэггүй” гэсэн тайлбар өгсөн. Сумдаас ОНХС-ийн хэрэгжилтийг хагас бүтэн

[45] ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

[46] Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын итгэвхтэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-аас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ.

жилээр авч байгаа боловч Сангийн яаманд мэдээлээгүй нь хариуцсан мэргэжилтэн хууль, журмаа судлаагүй, ажилдаа хариуцлагагүй хандсан байна.

ОНХС-ийн хэрэгжилт, үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийх аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн даргаар ахлуулсан ажлын хэсэг томилогдон ажилласан боловч ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт гаргаж, санал зөвлөмж гаргаагүйгээс өмнөх алдаа, зөрчлийг давтан гаргах нөхцөлийг бүрдүүлж байна.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар батлах тухай” журмын 4 дүгээр зүйлийн 10.1[47], 10.2[48], 10.3[49] дахь хэсгийг зөрчсөн байна.

Иймд цаашид аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам заавар батлах тухай” журмын 9 дүгээр зүйлийн 9.3[50], 9.7[51], 9.9[52] дахь заалтыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Аудитын явцад Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 11.2.3[53] дахь заалтын хэрэгжилтийг шалгахад ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудыг танилцуулсан зурагт хуудас, мэдээ судалгааг бүх /15/ сум хийсэн байна.

Аудитын явцад ОНХС-ийн сангийн талаар хэр мэдээлэлтэй байдаг эсэх талаар иргэдээс авсан санал асуулгаар судалгаанд оролцсон иргэдийн 28.5 хувь нь “хангалттай мэдээлэлтэй”, **60.7** хувь нь “**мэдээлэл хангалтгүй**” гэсэн хариулт өгч, 10.8 хувь нь огт хариулаагүй, ОНХС-гийн талаарх мэдээллийг хаанаас авдаг эсэхэд 25.6 хувь нь Засаг даргаас, 24.1 хувь “мэдээллийн самбар, телевиз, радио, иргэний танхимын ажилтан”-аас, 32 хувь нь “орон нутгийн иргэдээс авдаг” гэсэн хариулт өгч 18.3 хувь нь огт хариулаагүй байна.

Судалгааны дүнгээс харахад мэдээлэл олон нийтэд төдийлөн хүртээмжтэй биш, иргэд албан ёсны эх сурвалжаас мэдээлэл авдаггүй ихэвчлэн ам дамжсан ярианаас мэдээлэл авч байгаа нь үр дүн муутай байгааг харуулж байна.

ОНХС- гийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоо, БИНХ-ын хурлын ирцийг нэмэгдүүлэх, мэдээллийг хүртээмжтэй байдлаар олон нийтэд хүргэх талаар аймаг, сумын удирдлагууд анхаарч ажиллахгүй бол иргэд мэдээлэл муутай байсаар байна.

2018 онд “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт”-д хийсэн нийцлийн аудитаар Орон нутгийн хөгжлийн сангийн мэдээллийг 16 ТЕЗ шилэн дансны цахим

---

[47] Сум, дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн явцын хагас жилийн тайланг хил бүрийн 7 дугаар сарын 10-ний өдрийн дотор, бүтэн жилийн тайланг 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогын хэлтэст хүргүүлнэ. ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн эцсийн тайланд дүн шинжилгээ хийж, ажлын үр дүнг танилцуулах үүрэг бүхий ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсгийг Засаг даргын захирамжаар тухай бүр томилж ажиллуулна.

[48] Ажлын хэсэг ОНХС-ийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум, дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил бүрийн 2 дугаар сарын 25-ний өдрийн дотор хэлэлцүүлнэ.

[49] Аймаг, нийслэл ОНХС-ийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гарсан санал зөвлөмжийн хамт жил бүрийн 3 дугаар сарын 10-ны дотор Сангийн яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтэст ирүүлнэ.

[50] Аймаг, нийслэлийн Ххөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-ийн хэрэгжилтийн тайланг сум, дүүрэг тус бүрээр хагас жил тутамд гарган, дүгнэлт өгч цаашид даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний саналыг боловсруулан, аймаг нийслэлийн Засаг даргад танилцуулж, холбогдох асуудлаар тодорхой шийдвэрийг гаргуулна.

[51] Энэ журмын 9.3-т заасан дүгнэлт, Засаг даргын шийдвэрийг тухай шатны ИТХ-аар жил бүр, төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн иалаарх Засаг даргын мэдээллийг хамт хэлэлцүүлнэ.

[52] Аймаг нийслэлийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь Аймаг нийслэл сум дүүргийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэж жил бүрийн 3 дугаар сарын 10-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын ОНХС-ийн асуудал хариуцсан хэлтэст хүргүүлэх бөгөөд дараах мэдээллийг багтаана.

[53] Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг ЗДТГ-ын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд тогтмол мэдээлэх бөгөөд санхүүжилт хийгдэх тухай бүр мэдээллийг шинэчлэж байна.

хуудсаараа дамжуулан мэдээлэхээс 12 сумын ТЕЗ хугацаандаа мэдээлж, аймгийн ТЕЗ болон Дэрэн, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумын ТЕЗ огт мэдээлээгүй байна.

### 1.4. “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь бусад хууль тогтоомжтой нийцсэн байна.

Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар” нь Төсвийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл болон ОНХС-г хэрэгжүүлэхтэй холбоотой мөрдөгдөж буй хууль, тогтоомжтой нийцсэн байна.

## *БҮЛЭГ 2.* СХС-ийн зээлийн зарцуулалтад хяналт тавиагүйгээс хугацаа хэтрэлттэй авлага өсч, 1,235.0 сая төгрөгийн зээл хугацаандаа төвлөрөөгүй байна.

### 2.1. Сумдууд СХС-ийн төсвийг зөвхөн дансны үлдэгдэл дүнгээр баталж, зарлагыг зээл олголт болон зардлаар нь салгаж батлахгүй байна.

СХС-д 2014 оноос хойш ЗГ-аас санхүүжилт олгогдоогүй, зөвхөн өмнөх олгосон зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтөөс эх үүсвэр нь бүрдэж байна.

Аудитад хамрагдсан сумдын СХС-ийн ИТХ-аар баталсан төсвийг шалгахад ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “**Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын** 3.3.1[54], 3.5.7.[55]- т заасны дагуу эргэн төлөгдөх зээлийн хүүгийн орлого болон хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүү, алдангиас орох орлого, шүүх хяналтын байгууллагаар шийдвэрлүүлсэн авлагыг тухайн жилийн орлогод тооцож төлөвлөн, батлахгүй зөвхөн дансны үлдэгдэл дүнгээр баталж, зарлагыг зээл олголт болон зардлаар нь салгаж батлахгүй байна.

СХС-ийн 2017 оны эхний үлдэгдэл 747.2 сая төгрөг, тайлант онд 1,186.9 сая төгрөгийн орлого орсноос 91.5 хувь буюу 1,086.02 сая төгрөг нь үндсэн зээлийн эргэн төлөлт, 5.6 хувь буюу 66.7 сая төгрөг нь зээлийн хүүгээс, 2 хувь буюу 24.1 сая төгрөг алдангиас, 0.1 хувь буюу 1.6 сая төгрөг данс андуурсан орлогоос, 0.8 хувь буюу 8.9 сая төгрөг бусад орлогоос орсон байна. Хүснэгт : №3

СХС-ийн эх үүсврийн судалгаа /2017 он/

| № | Сумын нэр | Дансны эхний үлдэгдэл | Зээлийн төлөлтийн тооцоо | | | | Мөнгөн гүйлгээний тайлан /дансанд орсон орлого/ | Зөрүү |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Эргэн төлөгдсөн зээл, үндсэн төлбөр | Хүү | Алданги | Нийт орлого | | |
| 1 | Адаацаг | 38.06 | 71.71 | 5.03 | 0.53 | 77.27 | 77.27 | 0.00 |
| 2 | Баянжаргалан | 62.62 | 52.84 | 1.40 | | 54.23 | 63.09 | 8.86 |
| 3 | Говь-Угтаал | 96.04 | 61.62 | 1.99 | 1.09 | 64.70 | 64.70 | 0.00 |
| 4 | Гурвансайхан | 12.93 | 52.50 | 7.38 | 1.74 | 61.62 | 61.62 | 0.00 |
| 5 | Дэлгэрхангай | 36.14 | 51.74 | 2.99 | | 54.73 | 54.73 | 0.00 |

[54] сангийн төсвийг баталж, сангаас тухайн жилд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох;

[55]Сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг энэ журмын 1.8-д заасны дагуу боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах;

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | Дэлгэрцогт | 30.30 | 43.87 | 2.47 | 1.87 | 48.21 | 48.21 | 0.00 |
| 7 | Дэрэн | 31.12 | 43.87 | 3.14 | | 47.01 | 47.01 | 0.00 |
| 8 | Луус | 14.42 | 69.80 | 4.51 | | 74.31 | 74.67 | 0.36 |
| 9 | Өлзийт | 74.44 | 17.30 | 3.36 | | 20.65 | 20.65 | 0.00 |
| 10 | Өндөршил | 60.31 | 14.53 | 0.87 | | 15.40 | 12.24 | -3.16 |
| 11 | Сайнцагаан | 168.55 | 382.44 | 20.40 | 17.74 | 420.59 | 420.08 | -0.50 |
| 12 | Сайхан-овоо | 6.12 | 33.57 | 3.27 | | 36.84 | 38.06 | 1.22 |
| 13 | Хулд | 22.47 | 70.59 | 4.90 | | 75.50 | 75.50 | 0.00 |
| 14 | Цагаандэлгэр | 33.29 | 53.79 | 2.78 | 0.69 | 57.27 | 57.27 | 0.00 |
| 15 | Эрдэнэдалай | 60.41 | 69.19 | 2.19 | 0.39 | 71.77 | 71.77 | 0.00 |
| | **Нийт дүн** | **747.2** | **1,089.4** | **66.7** | **24.1** | **1,180.1** | **1,186.9** | **6.8** |

Луус, Сайхан-Овоо сумд Байгаль хамгаалах сангийн андуурагдсан 1.6 сая төгрөгийн орлогын гүйлгээг бусад орлогод бүртгэж, 0.4 сая төгрөгийг залруулга хийж, 1.2 сая төгрөгийг өглөг үүсгэн 2018 онд залруулга хийсэн байна.

Баянжаргалан суманд ашигт малтмалын тухай хуулийн тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эм Си Ти Ти” ХХК-ны ажиллах хүчний зөрүүгээс 2015 онд орж ирсэн 22.5 сая төгрөгийг Сум хөгжүүлэх санд байршуулан, төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хувийн орон сууц барих, засварлахад дэмжлэг үзүүлэх зорилгоор хөнгөлөлттэй зээл олгож эхэлсэн байна. Уг зээлээс 2017 онд 8.9 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт орсон байна. СХС-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар тухайн дансанд байршуулсан ажилчдад олгох орон сууцны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгийг ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан журмын 1.4 дэх хэсэгт /*Энэ журмын 1.3-т заасан дансанд сангийн хөрөнгөөс бусад хөрөнгө байршуулахыг хориглоно*./ гэж заасны дагуу данснаас татан авах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Аймгийн хэмжээнд 2016 оны жилийн эцсийн байдлаар 3,019.9 сая төгрөгийн зээлийн авлага бүртгэсний 41.7 хувь буюу 1,258.9 сая төгрөгийн зээл хугацаа хэтрэлттэй, */үүнээс 48.7 хувь буюу 613.4 сая төгрөг нь чанаргүй зээл/* хугацаандаа төвлөрөөгүй байна. Харин 2017 оны жилийн эцсийн байдлаар 3,162.8 сая төгрөгийн зээлийн авлага бүртгэсний 39 хувь буюу 1,235.0 сая төгрөгийн хугацаа хэтрэлттэй зээл /үүнээс 60.3 хувь буюу 744.7 сая төгрөг нь чанаргүй зээл/ буюу өмнөх оноос зээлийн үлдэгдэл 4.7 хувь буюу 142.9 сая төгрөгөөр өссөн ч хугацаа хэтрэлттэй зээлийн үлдэгдэл 1.9 хувь буюу 23.9 сая төгрөгөөр буурсан байна. /Хавсралт: № 8, График: №8/




Энэ нь 2017 оны 5 сард Адаацаг, Гурвансайхан, Эрдэнэдалай, Говь-Угтаал, Цагаандэлгэр, Өлзийт, Сайнцагаан гэсэн 7 суманд СХС-ийн зарцуулалт үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж хугацаа хэтрэлттэй 147 зээлдэгчийн 610.9 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлд төлбөрийн акт тогтоож, жилийн эцсээр 25.2 хувь буюу 154.5 сая

төгрөгийн зөрчил арилгаж, арга хэмжээ авсан боловч, хагас жилээс хойших хугацаа хэтрэлттэй зээлүүд нэмэгдсэн байна.

Дээрх байдлаас дүгнэхэд зээлийн авлагын 39 хувь буюу 1,235.0 сая төгрөгийг гэрээний хугацаандаа төвлөрүүлээгүй байна. Энэ нь зээлийг олгохдоо гэрээнд заасан хугацаанаас хамааруулан эргэн төлөлтийн хуваарь хийсэн боловч түүнд үндэслэн орлогын эх үүсвэрийг төлөвлөх, зээлийг гэрээнд заасан хугацаанд төвлөрүүлэх ажил хангалтгүй, урсгалаар явагдсантай холбоотой байна. Иймд 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар үлдсэн 8 сумын хугацаа хэтрэлттэй 179 зээлдэгчийн 471.4 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлд төлбөрийн акт тогтоож, СХС-ийн хөрөнгийг төвлөрүүлэхэд анхаарч ажиллахыг даалгасан.

СХС-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Адаацаг, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрхангай, Дэлгэрцогт, Дэрэн, Сайхан-Овоо, Хулд сумд СХС-ийн зээл, зээлийн хүү, алдангийн тооцооллыг дутуу тооцоолж, аккруэл сууриар бүртгээгүйгээс зээлийн гэрээний дараалаар төлөлтийг барагдуулалгүй тухайн онд тооцсон хүүгийн 12.4 хувь буюу 10.1 сая төгрөгийн хүүгийн авлагыг дутуу бүртгэсэн зөрчил илэрч, санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн. Тухайн онд нийт 86.7 сая төгрөгийн хүү тооцож, 81.7 хувь буюу 66.7 сая төгрөгийн хүү төвлөрүүлсэн байна. /Хавсралт: №9, График: №9 /




СХС-ийн журмын 1.7[56] -д заасны дагуу хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.1-0.5 хүртэл хувиар сумд харилцан адилгүй гэрээг байгуулсан байна. Гэвч Сайнцагаан, Эрдэнэдалай, Адаацаг, Говь-Угтаал, Гурвансайхан, Дэлгэрцогт, Цагаандэлгэр сумд зээлийн хугацаа хэтрүүлсэн хоног тутамд харилцан адилгүйгээр 46.2 сая төгрөгийн алдангийг тооцож, 51.8 хувь буюу 24.1 сая төгрөгийн алдангийг төвлөрүүлсэн байна. Харин Баянжаргалан, Дэрэн, Луус, Өлзийт, Өндөршил, Хулд сумд алданги тооцоогүй байна.

2017 онд сум хөгжүүлэх санд нийт 128.0 сая төгрөгийн зээлийн хүү, алдангийг тооцоолж, үүнээс 70.9 хувь буюу 90.7 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

СХС-ийн зээл, зээлийн хүү, алдангийг нарийвчлан тооцож, санхүүгийн тайлан балансад үнэн зөв тусгах зорилгоор 2016 онд СХС-ийн санхүүгийн программыг сум тус бүр 0.8 сая төгрөгөөр худалдан авсан боловч тус программыг зарим сум огт ашиглаагүй, зээл, зээлийн хүү алдангийг гараар тооцож байгаа тул төсвийн хөрөнгийг ямарч үр ашиггүй зарцуулсан байна.

Хугацаа хэтрэлттэй зээлийн үлдэгдэлд алданги тооцоогүй сумдад хууль, журам гэрээнд заасны дагуу зээлийн хүү, алдангийг бүрэн тооцож, төвлөрүүлэх зөвлөмж хүргүүллээ.

## 2.2 СХС-ийн зээлийн гэрээний заалтыг мөрдөөгүй, ажлын байр нэмэгдсэн эсэхийг тодорхойлох боломжгүй байна.

Сумд СХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийг сонгон шалгаруулах орон тооны бус зөвлөлийг 2017 онд шинэчлэн баталсан боловч Хулд сум орон тооны

[56] Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0.5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах Зээлийн гэрээнд тодорхой тусгана.

зөвлөлийг журмын дагуу батлаагүй байсан тул зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

2017 онд СХС-аас Дэрэн, Цагаандэлгэр, Эрдэнэдалай сумд зээл олгоогүй байна. Харин үлдсэн 12 сум 25 удаагийн хурлаар 234 төслийг хэлэлцэж, 132 төслийг сонгон шалгаруулж, 1,197.6 сая төгрөгийн зээл олгож, Баянжаргалан сум орон сууцны хөнгөлөлтийн зээлд 9.4 сая төгрөгийг олгосон байна. Төсөл сонгон шалгаруулалтыг шалгах үед дараах зөрчлүүд илэрлээ. /Хавсралт №10/ Үүнд:

- *Гурвансайхан, Хулд, Говь-Угтаал, Сайхан-Овоо сумд СХС-ийн журмын 1.11*[57] *заасныг зөрчин сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сумын ИТХ тогтоогүй байхад 54 төслийг сонгон шалгаруулж, 274.7 сая төгрөгийн зээл олгосон байна;*
- *Баянжаргалан, Хулд, Дэлгэрхангай сумд зээл авсан иргэдийн хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрэн хангаж, баримтжуулан хадгалаагүй, зээлийн болон барьцаа хөрөнгийн гэрээг батлагдсан маягтын дагуу хийж, барьцаалсан эд хөрөнгийн гэрчилгээний эх хувийг аваагүй, хяналт тавьж ажиллаагүй;*
- *Адаацаг сум төсөл сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлөөр сонгон шалгаруулаагүй Х.Оюундарьд 1.5 сая төгрөгийн зээлийг сумын Засаг даргын захирамжаар олгосон байна.*

Дээрх зөрчлүүд нь ажил хариуцсан албан хаагч 2016 онд шинэчлэн баталсан журмыг уншиж, судлаагүй, хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандсантай холбоотой байна. Иймд Хулд сумын МЭҮТ-ийн жижиг дунд үйлдвэрлэл, сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтэн Ц.Мөнхсүхэд хариуцлага тооцох санал хүргүүлж, сумдын Засаг даргад зөрчлийг таслан зогсоож, дахин давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлагыг хүргүүлсэн. /Хавсралт №16/

Мөн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Гурвансайхан сумын Засаг даргын үүрэг гүйцэтгэгч С.Өлзийбуян 2017 онд Сум хөгжүүлэх сангийн журмыг зөрчин, төсөл сонгон шалгаруулах ИТХ-ын тов зарлаагүй байхад, хүчин төгөлдөр бус комисс хуралдуулан, тэргүүлэх чиглэлд ороогүй, нэг төсөлд олгох дээд хэмжээнээс хэтрүүлэн, Засаг даргын А/110 дугаар захирамжаар сум хөгжүүлэх сангаас хугацаа хэтрэлттэй зээлтэй М.Эрдэнэсүрэнд 15.0 сая төгрөг, Ш.Хадбаатарт 18.0 сая төгрөгийн зээл олгож, эрх бүхий зарим этгээд давуу байдал олгосон зөрчил илэрсэн. Иймд Авлигын эсрэг хуулийн 7.1.3.-д /*албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах;*/ гэж заасны дагуу асуудлыг шалгуулахаар Дундговь аймаг дахь Цагдаагийн газарт шилжүүлсэн.

2017 онд зээл олгосон 8 сумын зээлдэгч нартай хийсэн гэрээ, батлагдсан загварын дагуу хийгдэж, гэрээний заалтуудыг мөрдөж, ажилласан эсэхийг шалгахад 50 хувь буюу Адаацаг, Луус, Сайнцагаан, Өндөршил зэрэг 4 сум шинэ батлагдсан гэрээний загвараар гэрээг хийсэн байна. Харин үлдсэн Баянжаргалан, Гурвансайхан, Дэлгэрхангай, Хулд сумд хуучин гэрээний загвараар гэрээг хийсэн боловч гэрээний зарим заалтуудыг хасаж, өөрчилсөн байна. Жишээ нь:

1. Гэрээний ерөнхий зүйлийн харилцан тохиролцсон хэсэг болон гэрээ байгуулсан хэсгүүдийг сумд харилцан адилгүй янз бүрээр гэрээг байгуулсан байна. Тухайлбал:

[57] Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг сангийн хөрөнгийн эх үүсвэрийн 20-иос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно.

- *Адаацаг сум гэрээний ерөнхий зүйлийн харилцан тохиролцсон хэсэгт зөвхөн Засаг дарга, зээлдэгч 2 тохиролцож, гэрээ байгуулсан хэсэгт мөн гарын үсэг зурсан;*
- *Гурвансайхан сум гэрээнд сумын Засаг дарга, зээлдэгч 2 тохиролцож, гэрээ байгуулсан хэсэгт Засаг дарга, Санхүүгийн албаны дарга, зээлдэгч нар гарын үсэг зурсан;*
- *Хулд сум гэрээг Засаг дарга баталж, тохиролцсон хэсэг болон гэрээ байгуулсан хэсэгт хариуцсан мэргэжилтэн, зээлдэгч 2 гарын үсэг зурсан;*
- *Сайнцагаан сум гэрээнд харилцан тохиролцсон болон гэрээ байгуулсан хэсэгт Засаг дарга, мэргэжилтэн, зээлдэгч, хамтран зээлдэгч нар бүгд зурсан;*
- *Өндөршил сум 2017 оны зээлдэгч нартай хийсэн гэрээнүүд дээр харилцан тохиролцсон хэсэг дээр ганцхан Засаг дарга бичигдэж, хэнтэй тохиролцсон эсэх нь тодорхойгүй, зээлдэгчийн нэрийг оруулаагүй зөвхөн гэрээ байгуулсан хэсэгт Засаг дарга, зээлдэгч 2-оор гарын үсэг зуруулсан байна.*

2. Зээлийн гэрээнд төсөл хэрэгжүүлээгүй, зориулалт бус ашигласан үед ямар арга хэмжээ авах талаар мөн харилцан адилгүй тусгасан байна.

- *Шинэ гэрээний загвараар гэрээ байгуулсан сумд гэрээний маягтыг өөрчлөөгүй бөгөөд гэрээний 2.7-д /Гэрээний 2.8-д заасан тохиолдол үүссэн бол талууд гэрээний 2.2-д заасан зээлийн хүүг дараах хүүнд шилжүүлэхээр тохиролцов. Ийнхүү шилжүүлэхдээ талууд дахин нэмэлт гэрээ байгуулахгүйгээр тохиролцов. Үүнд: Зээлийн хүү /Үндсэн болон хэтэрсэн хугацааны хүү/ жилийн 24 хувь, сарын 2 хувь/ гэж заасан байна. Иймд аудитын явцад 2017 онд нийт 13.0 сая төгрөгийн зээл авч төслөө хэрэгжүүлээгүй, зориулалт бус зарцуулсан Адаацаг сумын Ж.Сүнжидмаа, Г.Оюунбат, Э.Ариунбуян нарын зээлийн үлдэгдлийг гэрээний дагуу хүүнд шилжүүлэх албан шаардлагыг хүргүүлсэн.*
- *Хуучин гэрээний загвараар гэрээ байгуулсан сумд уг заалтыг гэрээнд өөр өөрөөр оруулж, байгуулсан байна. Иймд аудитын явцад илэрсэн зөрчлийг гэрээнд заасны дагуу арга хэмжээ авах албан шаардлагыг хүргүүлсэн. Үүнд:*
  - *2017 онд зээл авч, зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаагүй, төслөө хэрэгжүүлээгүй Дэлгэрхангай сумын Г.Буяннэмэх 3.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг гэрээний 2.6-д /Зээлийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан бол зээлийн төлөгдөөгүй үлдэгдлээс өдрийн 1 хувийн торгууль төлж зээлийг буцаан татна/ заасны дагуу арга хэмжээ авах;*
  - *2017 онд зээл авч, зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, төслөө хэрэгжүүлээгүй Баянжаргалан сумын Э.Маралмаа, Л.Цэрэнбаяр нарын 13.0 сая төгрөгийн зээлийн үлдэгдлийг гэрээний 6.2-д /Олгогдсон зээлийг зориулалт бусаар ашигласан тохиолдолд гэрээг цуцалж, санхүүжилтийг буцаан татна/ заасны дагуу арга хэмжээ авах.*

Аудитад хамрагдсан сумдын төсөл хэрэгжүүлэгч нараар очиж, төсөл хэрэгжиж буй эсэхийг шалгах үед ихэнх төсөл хэрэгжүүлэгч нар хот, хөдөө явсан эзгүй, цоожтой байж, төсөл хэрэгжүүлэгч нартай уулзаж чадаагүй учраас төсөл хэрэгжсэн үгүйг тогтооход хүндрэлтэй байлаа.

Мөн төсөл хэрэгжээгүй, зориулалт бус зарцуулсан зээлдэгчид гэрээнд заасны дагуу арга хэмжээ авч, зээлийг буцаан татсан, эсвэл гэрээнд заасан өндөр хүүнд шилжүүлсэн болон гэрээний бусад заалттай холбоотой арга хэмжээ авч ажилласан сум байсангүй.

Цаашид зээлийн гэрээг шинээр батлагдсан маягтын дагуу байгуулж, гэрээг зөрчсөн зээлдэгч нарт журам болон гэрээнд заасан арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт зөвлөмжөөр хүргүүллээ.

СХС-аас 2017 онд нийт 1,221.6 сая төгрөгийг зарцуулж, 98.8 хувь буюу 132 төсөлд 1,207.0 сая төгрөгийн зээл олгож, үлдсэн 1.2 хувь буюу 14.6 сая төгрөгийг бусад зардалд зарцуулсан байна. Бусад зардлын 42.1 хувь буюу 6.1 сая төгрөгийг

11 сум зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 13.2 буюу 1.9 сая төгрөгийг 10 сум сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих зардалд журмын дагуу зарцуулж, 16.6 хувь буюу 2.4 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, 28.2 хувь буюу 4.1 сая төгрөгийг хугацаа хэтрэлттэй зээлдэгчийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх зардалд зарцуулсан байна. /Хавсралт №11, График №10/




2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар зориулалт бус зарцуулсан 1.5 сая төгрөгт төлбөрийн акт тогтоож, 0.9 сая төгрөгийн зөрчлийг арилгуулах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн. Сумдын СХС хариуцсан мэргэжилтнүүд 2017 оны жилийн эцсийн байдлаар үлдэгдэлтэй байгаа зээлүүдийн хувьд шинээр 480 ажлын байр нэмэгдүүлж, үүнээс хадгалагдсан ажлын байр 264 гэсэн тоон мэдээлэл өгсөн. Гэвч СХС-ийн хөрөнгийн зориулалт, ашиглалт, төслийн үр дүнд чиглэсэн хяналт шалгалтын дүнгээс харахад сангийн хөрөнгийн үр дүнд ажлын байр нэмэгдсэн нь тодорхой бус, эргэлзээтэй, аудитаар тодорхойлоход хүндрэлтэй байна.

Сумдын удирдлагууд болон холбогдох мэргэжилтнүүдтэй хийсэн ярилцлага, уулзалтын үр дүнгээс харахад шинээр нэмэгдсэн ажлын байр тодорхой хэсэг хугацаанд хадгалагддаг ч байнгын ажлын байр дорвитой нэмэгдэхгүй байна гэжээ. Үүнээс дүгнэхэд СХС-аас төсөл хэрэгжүүлэгч нар өмнөх бизнесээ санхүүжүүлэн, түр ажлын байрыг л нэмэгдүүлсэн гэж үзэхээр байна.

## 2.3. Сумдын СХС-ийн 2017 оны зарцуулалтад орон тооны бус зөвлөлийн хяналт хийгдээгүй, зээлийн хүү, авлагыг тайланд бүрэн тусгаагүй байна.

Сумдын СХС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн 2017 онд хийсэн ажлын тайлантай танилцахад Адаацаг, Дэлгэрхангай, Өндөршил, Хулд, Дэрэн сумд хяналт хийгээгүй байна. Бусад сумдын хувьд зээл авсан иргэдтэй уулзаж, зээлийн ашиглалт, үйл ажиллагаатай танилцаж, хугацаа хэтрэлттэй зээлийг төлүүлэх үйл ажиллагаанд хяналт тавьж, мэдэгдэл өгч ажилласан гэсэн боловч Сайнцагаан, Баянжаргалан, Луус сумдаас бусад сумд хийсэн ажлын тайлангаа баримтжуулан хадгалаагүй байна.

Сайнцагаан сумын орон тооны бус хяналтын зөвлөл 2017 онд сайн ажиллаж, төсөл сонгон шалгаруулах үйл явц болон зээл авсан иргэдийн хувийн хэргийн бүрдэл, зээлийн гэрээ, сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт зэрэгт хяналт хийж, Засаг дарга, орон тооны бус зөвлөлд 4 санал, СХС хариуцсан мэргэжилтэнд 3 зөвлөмж өгч ажилласан байна.

Төрийн аудитын газраас 2017 онд гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн аудитуудыг хийж, хугацаа хэтрэлттэй зээлийн үлдэгдлийг бууруулах хугацаатай төлбөрийн актуудыг тавьж, аймгийн Засаг даргад арга хэмжээ авч ажиллах зөвлөмж хүргүүлэн, бүх сумдын Засаг дарга нартай хугацаа хэтрэлттэй зээлийг барагдуулах хугацааг тохиролцож, албажуулснаар 2018 оноос бүх сумдын орон тооны бус хяналтын зөвлөл, хугацаа хэтрэлттэй зээлийг бууруулах тал дээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Сангийн 2017 оны санхүүгийн тайлангийн авлагын бүртгэлийг ажил хариуцсан мэргэжилтний зээл, зээлийн хүү, алдангийн бүртгэлтэй тулган шалгахад дараах зөрүү, зөрчлүүд гарсан. /Хавсралт №12/ Үүнд:

- *Баянжаргалан сумын авлагын дансны эхний үлдэгдэл 26.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 28.1 сая төгрөгөөр зөрсөн нь орон сууцны хөнгөлөлтийн зээл оны эхэнд 23.6 сая төгрөг, оны эцэст 25.4 сая төгрөг. Мөн насжилт өндөртэй хэзээ авсан нь тодорхойгүй сумын ЗДТГ-аас авах 1.7 сая төгрөг, Соёлын төвөөс авах 1.0 сая төгрөгийн авлага;*
- *Говь-Угтаал сумын авлагын дансны эхний үлдэгдэл 3.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4.9 сая төгрөгөөр зөрсөн нь санхүүгийн тайландаа зөвхөн үндсэн зээлээ бүртгэж, хүү алдангийг бүртгээгүйтэй холбоотой;*
- *Дэлгэрхангай болон Сайхан-Овоо сумдын оны эхний 16.0 сая болон 19.5 сая төгрөг, оны эцэст 14.0 сая болон 17.3 сая төгрөгийн зөрүүнүүд нь малжуулах хөтөлбөрийн зээлийн үлдэгдлийн авлага;*
- *Сайнцагаан сумын авлагын зөрүү нь шүүхийн шийдвэр гүйцэтгэхийн зардлын авлага оны эхэнд 1.2 сая төгрөг байгаад оны эцэст 2.7 сая төгрөг болсонтой холбоотой;*
- *Дэлгэрцогт сумын оны эхэнд болон эцэст гарсан 1.7 сая төгрөг нь насжилт өндөртэй хэзээ авсан нь тодорхойгүй сумын ЗДТГ-аас авах авлага;*
- *Цагаандэлгэр сумын оны эхний 2.0 сая төгрөг Цац цагаан хоршооны өмнөх 2013-2014 онд төлсөн 2.0 сая төгрөгийг бүртгээгүй байсан зөрүүг залруулсан байна;*
- *Дэрэн сумын оны эцсийн 0.3 сая төгрөгийн зөрүү нь 2018 оны санхүүгийн аудитаар тооцоолсон зээлийн хүүгийн зөрүү.*

Дээрх зөрүүг харахад насжилт өндөртэй төсвийн байгууллага хоорондын авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, сум хөгжүүлэх сангийн дансанд өөр зээлийн үлдэгдлийг байршуулсан, мэргэжилтэн болон нягтлан бодогчийн зээлийн авлага үлдэгдэл хоорондоо зөрүүтэй, тооцоо нийлдэггүй, ажлын уялдаа холбоо муу байгааг харуулж байна.

Аудитын явцад Баянжаргалан сумын насжилт өндөртэй 2.7 сая төгрөгийг барагдуулах арга хэмжээ авах, Говь-Угтаал сумын Сум хөгжүүлэх сангийн 4.9 сая төгрөгийн хүүг санхүүгийн программд хууль, журмын дагуу бүртгэх, Дэлгэрхангай болон Сайхан-Овоо сумдын малжуулах хөтөлбөрийн авлагын үлдэгдлийг Сум хөгжүүлэх сангийн дансанд журмын дагуу байршуулахгүй байх талаар албан шаардлагыг тус тус хүргүүллээ.

Төрийн аудитын газраас 2017 онд гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитаар нийт 326 зээлдэгчийн 1,082.4 сая төгрөгийн хугацаа хэтрэлттэй зээлд төлбөрийн акт тогтоосон. 2017 оны жилийн эцсийн байдлаар 363.2 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 68 зээлдэгчийг шүүхэд, 86.0 сая төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй 18 зээлдэгчийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн байна./ График: №11 Хавсралт :№13/




2018 оны 9 сарын байдлаар Баянжаргалан, Говь-Угтаал, Луус болон Цагаандэлгэр сумд хугацаа хэтрэлттэй зээлдэгчдийг шүүхэд шилжүүлээгүй байна. Нийт хугацаа хэтрэлттэй зээлдэгчдийн 40 хувь буюу 131 зээлдэгчийн 642.3 сая төгрөгийн зээлийг шүүхэд, 11 хувь буюу 37 зээлдэгчийн 178.8 сая төгрөгийн зээлийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн байна. Гэвч Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжсэн зээл шийдвэрлэгдэхгүй удаааширч байна.

Сумдын СХС-д өмнөх онуудын хугацаа хэтрэлттэй болон зориулалтын дагуу ашиглаагүй зээлдэгчдийн нэгдсэн мэдээлэл байхгүй байна. Иймд аудитын явцад Сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн нэгдсэн судалгаа гаргаж, хяналт тавих зөвлөмжийг сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.

### 2.4. Сум хөгжүүлэх сангийн журамд Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн зээлтэй холбогдон гарах зардал болон хариуцсан мэргэжилтэнд тавих шаардлагыг нэмж тусгах шаардлагатай байна.

СХС-ийн хугацаа хэтрэлттэй зээлдэгчдийг Шүүх болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэхэд холбогдох зардлыг хаанаас гаргаж, шийдвэрлэх нь ЗГ-ын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-д тусгаагүй, хуучин гэрээнд нарийн заалт байхгүй, харин шинэ гэрээнд зээлдэгч хариуцна гэж заасан боловч 2017 онд хүчинтэй байсан Монгол Улсын Хууль зүйн сайдын 2013 оны А/181 дугаар тушаалийн 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Шүүхийн гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох журам”-ын 3.1 дэх хэсэг /*шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр авагчтай гэрээ байгуулж, зардлыг тухай бүрт нь гаргуулна.*/, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Шийдвэр гүйцэтгэгчид урамшуулал олгох журам”-ын 1.2 дахь хэсэг /*шийдвэр гүйцэтгэх ажиллагааг хэсэгчлэн биелүүлсэн болон хуульд заасны дагуу дуусгавар болгосны дараа төлбөр авагчид олгох мөнгөн болон эд хөрөнгийн үнийн дүнгээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 9.2, 83.1-т заасны дагуу энэ журмын 3.1-т заасан хувь хэмжээгээр суутгал хийнэ./* гэж заасан байна.

Иймд зарим сумд тухайн зардлыг Сум хөгжүүлэх сангаас, зарим нь сумын ЗДТГ-аас зарцуулж байгаа нь харилцан адилгүй байна.

2018 оны 6 сараас “Шүүхийн гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох журам”, “Шийдвэр гүйцэтгэгчид урамшуулал олгох журам” Хууль зүй, дотоод хэргийн сайд, сангийн сайдын хамтарсан 2018 оны А/107/132 дугаар тушаалаар хүчингүй болж, “Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг тодорхойлох, зарцуулах, төлбөр авагчид буцаан олгох журам” батлагдсан байна. Уг журмын 1.2 дахь хэсэгт/*Иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардлыг энэ журамд заасан хэмжээгээр тооцон гаргуулж, төлбөр төлөгчөөс нөхөн төлүүлж, төлбөр авагчид олгоно.*/, 3.3 дахь хэсэгт /*Энэ журмын 2.1 заасан зардлыг тухай бүрт гаргуулна*/ гэж заасан нь Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмын 1.9.-д/*Сангийн хөрөнгийг энэ журмын 1.5, 1.8-д заасанаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.*/ заасантай зөрчилдөж байна.

Иймд "Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам"-д шүүх болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаатай холбоотой зардлыг хаанаас гаргахыг тодорхой тусгаж, нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

Аудит хийх явцад Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтнүүдийн санхүүгийн мэдлэг дутмагаас хүү, алдангийг дутуу, буруу тооцоолсон, огт тооцоолоогүй, баримт материалыг журмын дагуу бүрдүүлдэггүй, мэдээ судалгааг гаргаж өгөхдөө буруу гаргаж, өгсөн зэрэг зөрчлүүд их гарсан. Аудитаар сумдын Сум хөгжүүлэх сан хариуцсан мэргэжилтнүүдийн боловсрол, мэргэжлийн судалгаа авч үзэхэд Луус сумын мэргэжилтнээс бусад сумдын мэргэжилтнүүд бүгд мэргэжлийн бус, мал эмнэлэг, хөдөө аж ахуйн мэргэжлийн хүмүүс байсан. Мөн сумын Засаг дарга, мэргэжилтнүүдтэй уулзалт ярилцлага хийх үед олон давхар ажил хийдэг, ажлын ачаалал их байдгаас яг Сум хөгжүүлэх сангийн хэрэгжилт дээр бүрэн дүүрэн ажиллаж чаддаггүй, санхүүгийн мэдлэг дутдаг гэсэн шалтгаан, тайлбарыг өгсөн.

Сум хөгжүүлэх сангийн мэргэжилтний ажил үүргийн хуваарь нь банкны эдийн засагчийн ажил, үүрэгтэй адил тул энэ асуудал дээр анхаарал хандуулах шаардлагатай болсон байна.

Иймд дээрх нөхцөл байдлаас шалтгаалан мал эмнэлгийн бүтэц зохион байгуулалт өөрчлөгдөж байгаатай холбогдуулан, жижиг дунд үйлдвэрлэл, СХС хариуцсан мэргэжилтний ажлын байранд санхүүгийн боловсролтой албан хаагч авч ажиллуулахыг журамд тусгаж өгөх шаардлагатай байна.

## ***БҮЛЭГ 3.*** **Өмнөх онд өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.**

### 3.1. Өмнөх онд ОНХС-ийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хариуг 100 хувьтай ирүүлсэн ч зөрчил дахин гарсаар байна.

ОНХС-гийн 2016 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар нийт 1,119.8 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлэн 1,119.8 сая төгрөгийн 21 албан шаардлага, 17 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн талаар хариу ирүүлсэн байна.

Аймаг, сумын төсвийн захирагч нар аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хариуг хугацаанд нь хүргүүлж байгаа ч аудитаар өмнөх жилд гарч байсан зөрчил давтагдан гарсаар байгаа нь зөвлөмжийг хэрэгжүүлэх ажилд ач холбогдол өгдөггүй, зөрчлийг арилгасан гэсэн худал мэдээллийг төрийн аудитын байгууллагад өгч байгаатай холбоотой байна.

Энэ нь Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 15.1.2 /Хууль ёсны дагуу шаардсан холбогдох мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл санаатайгаар худал мэдээлэл өгсөн, эсхүл төөрөгдүүлсэн;/ -дахь заалтыг зөрчиж байгаа бөгөөд цаашид дээрх зөрчлийг гаргасан албан тушаалтанд тус заалтаар хариуцлага тооцогдохыг эрх бүхий албан тушаалтнууд анхаарч ажиллах хэрэгтэй.

Иймд Төрийн аудитын байгууллагаас өгсөн төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг тооцон хэрэгжилтийг хангуулж, хариу ирүүлэхдээ нотлох зүйлийн хамт ирүүлж байх шаардлагатай байна.

ОНХС-гийн аудитаар илэрсэн зөрчлийн дүнг өмнөх аудитын дүнтэй харьцуулж үзэхэд илэрсэн зөрчлийн дүн өмнөх оноос нийт дүнгээрээ 845.2 сая төгрөгөөр буюу 75.5 хувиар буурсан үзүүлэлттэй байна. 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар 404.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь нийцлийн аудитын зөрчил өмнөх оноос буурахад нөлөөлж байна. Зөрчлийг агуулгаар нь авч үзвэл өмнөх онд гарч байсан зөрчлүүд дахин давтагдан гарсаар байна.

Хүснэгт №5

**2016, 2017 онд ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтад хийгдсэн нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийн судалгаа**

/ сая.төг /

| Он | Илэрсэн зөрчлийн дүн | Залруулсан алдааны дүн | Залруулаагүй алдааны дүн | Тогтоогдсон | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Акт | Албан шаардлага |
| **2017** | 1,119.8 | - | 1,119.8 | - | 1,119.8 |
| **2018** | 274.6 | - | 274.6 | 0.4 | 274.2 |
| **Өсөлт бууралт** | -845.2 | - | -845.2 | 4.0 | -845.6 |

Аудитаар илэрсэн зөрчлийг тухайн оны ОНХС-ийн эх үүсвэртэй харьцуулахад 2014 онд 83.6 хувийг, 2015 онд 27.2 хувийг, 2016 онд 20.4 хувийг, 2017 онд 8.2 хувийг тус тус эзэлж байгаа нь жил ирэх тусам зөрчлийн хэмжээ буурсан үзүүлэлттэй байна.

*(График: №7)*




2017 оны ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар нийт 274.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь өмнөх оноос 845.6 сая төгрөгөөр, эх үүсвэртэй нь харьцуулахад 12.2 хувиар буурсан боловч өмнө гарсан зөрчлүүд арилахгүй, их бага хэмжээгээр давтагдаж байна.

Энэ нь орон нутгийн удирдлагууд сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл, арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, журам, зааврыг мөрдөхгүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, дээд шатны удирдлагаас зөрчил гаргасан албан тушаалтнуудтай хариуцлага тооцохгүй байгаатай холбоотой байна.

### 3.2. СХС-ийн өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна.

2017 оны 5 сард Төрийн аудитын газраас “Сум хөгжүүлэх сангийн зарцуулалт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, 7 сумын хугацаа хэтрэлттэй зээлд 610.9 сая төгрөгийн төлбөрийн акт, 94.6 сая төгрөгийн албан шаардлага өгөгдсөн байна.




/График: №12, Хавсралт №14/Харин 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар үлдсэн 8 суманд 471.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 28.6 сая төгрөгийн албан шаардлага хүргэгдэж, 6 сумын Засаг даргад хариуцлага тооцуулах санал хүргүүлсэн.

